АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН СОНГУУЛЬТ АЛБАН ТУШААЛ ДАХЬ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ

Empowered lives.
Resilient nations.

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зургаан чиглэл

Ази, Номхон далайн бүс нутгийн сонгуульт албан тушаал дахь жендэрийн тэгш байдал: Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зургаан чиглэл

Энэхүү бүтээлд дурдагдсан үзэл бодол, дүгнэлт, санал нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, түүний Гүйцэтгэх зөвлөл, эсвэл гишүүн орнуудын байр суурийг илэрхийлээгүй болно. Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан.

Зохиогчийн эрх © 2012
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр бүтээлийг хэсэгчлэн болон бүтнээр хувилах, байршуулах, тараахыг хориглоно.

Хэвлэсэн:
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
Ази, Номхон Далайн Бүсийн Төв
Бангкок хот, Тайланд

Empowered lives.
Resilient nations.

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН СОНГУУЛЬТ АЛБАН ТУШААЛ ДАХЬ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зургаан чиглэл

ПИППА НОРРИС
ХАРВАРДЫН ИХ СУРГУУЛЬ, СИДНЕЙН ИХ СУРГУУЛЬ)

Тайланд, Бангкок
2012 он

ТАЛАРХАЛ

Энэхүү номыг туурвихад өөрсдийн хувь нэмрийг оруулсан бүх оролцогч, тэдний дундаас бүтээлийн эх санааг дэвшүүлэхийн зэрэгцээ ном болон гарахад идэвхийлэн ажилласан Харвард, Сиднейн их сургуулийн профессор Пиппа Норрист НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн зүгээс талархал илэрхийлж байна.

ТЭРГҮҮЛЭХ ЗОХИОГЧ: Профессор Пиппа Норрис

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД: Саймон Алексис Финли, Харалд Форуд, Полине Тамесис

ХЯНАН ТОХИОЛДУУЛЖ, СЭТГЭГДЛЭЭ ХУВААЛЦСАН:
Энни Серрано, Бишва Наф, Шармейн Родригез, Чери Харт, Жин Мунро, Жули Баллингтон, Нацуко Канеяама, Маяа Няголова, Ниража Гопал Жаял, Омар Сиддик, Прагя Башял, Рохини Коли, Шоко Ишикава

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:
Эверет Берг

ЗАГВАР ДИЗАЙН:
Инис Коммуникейшн

ХАВТАСНЫ ГЭРЭЛ ЗУРАГ:
Фаяз Кабли / Ройтерс агентлаг

МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН:
Д.Гансүх

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:
Л.Бархас, Б.Энхсайхан

АГУУЛГА

Өмнөх үг 5

I. Өмнөх үг 6

II. Хураангуй 8

III. Ази, Номхон далайн бүс нутгийн сонгуульт албан тушаал дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн чиг хандлага 21

IV. Үндсэн хууль 30

V. Сонгуулийн тогтолцоо 32

VI. Суудал хадгалах болон хуулиар тогтоосон квот 36

VII. Нэр дэвшигчийг сонгох намын дотоод дүрэм, үйл явц 51

VIII. Чадавхи бэхжүүлэх 55

IX. Сонгуулиар бүрддэг байгууллагын жендэрийн мэдрэмжтэй дүрэм, журам 65

X. Дүгнэлт, цаашид авах арга хэмжээ 67

XI. Ашигласан номын жагсаалт 70

XII. Ишлэл 74

ӨМНӨХ ҮГ

Жендэрийн тэгш байдал нь өнөөдөр ардчиллыг хөгжүүлэн, хүний эрхийг дээдэлж буй улс орон бүр шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо, ялангуяа эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулж байна.

Монгол улс Мянганы Хөгжлийн 3 дахь Зорилтод заасны дагуу улс төр, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог 2015 он гэхэд 30 хувьд хүргэх зорилт тавьсан. 2011 онд шинээр баталсан УИХ-ын сонгуулийн тухай Монгол улсын хуулинд 20-иос доошгүй хувь нь эмэгтэй нэр дэвшигч байхыг хуульчилж өгсөн. Улс төрийн намууд ч сонгуульд өрсөлдөхдөө дээрх хуулийн шаардлагыг биелүүлэн ажиллаж байна.

Өнөөдөр УИХ-ын нийт 76 гишүүний 11 нь эмэгтэй гишүүд сонгогдон ажиллаж байна. Мөн шинэчлэлийн Засгийн газрын бүрэлдэхүүнд нийт 19 сайдын 3 нь эмэгтэй сайд, төрийн захиргааны төв байгууллагуудад дэд сайд 3 тус тус томилогдон ажиллаж байна. Ийнхүү нийгэм дэх эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэмэгдүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн бодлого нь Монгол улсад хүний эрхийг хангах, хамгаалах тэдний оролцоог нэмэгдүүлэх чухал алхам болж байна.

Цаашид ч Шинэчлэлийн Засгийн газар нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, боломжийг бий болгох таатай орчныг бүрдүүлэх, тулгамдсан асуудлыг хүмүүст ээлтэйгээр шийдвэрлэхийн төлөө хүчин чармайлт гарган ажиллах болно.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаарх мэдээлэл бүхий гарын авлагыг орчуулан хэвлэж, хамтран ажиллаж байгаад талархлаа илэрхийлье.

Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Жендэрийн Үндэсний хорооны дэд дарга

Л.Гансүх

I. ӨМНӨХ ҮГ

Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо, хувь нэмэр нь хүний хөгжил, ардчилсан засаглалын урьдчилсан нөхцөл болдог. Ази, Номхон далайн бүс нутагт дэлхийн нийт хүн амын гуравны хоёр нь амьдарч, сүүлийн жилүүдэд эдийн засаг нь үсрэнгүй хөгжсөн боловч тус бүс нутгийн олон улс оронд улс төр дэх жендэрийн тэгш байдал хангагдаагүй хэвээр байна. Хууль тогтоох байгууллагын нийт суудлын дунджаар 18.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна гэсэн үзүүлэлттэйгээр тус бүс нутаг эмэгтэйчүүдийн оролцооны хувьд дэлхийд доороосоо хоёрт жагсаж байна.

Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо, жендэрийн тэгш байдлыг дэмжих нь хөгжил, хүний эрхийн асуудал төдийгүй ёс зүйн үүрэг хариуцлага юм. Өргөн төлөөлөл бүхий парламент иргэний, ардчилсан оролцоог тэтгэх чадвартай байдаг. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд тулгарах саадыг арилгаж, хүйсээр алагчлах бүх хэлбэрийг үгүй болгож, эмэгтэйчүүдийн боломжийг нээж, улс төр, нийгэм, эдийн засгийн үр шимийг хүртэх нь Ази, Номхон далайн бүс нутаг төдийгүй дэлхий дахинд чухал юм. Хүн амын тал хувь нь бүрэн оролцдоггүй улс төрийн тогтолцоо нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн улс төр, эдийн засгийн шийдвэрт нөлөөлж, үр ашгаас нь хүртэх боломжийг хязгаарладаг.

Дэлхий даяар парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувийг 30-д хүргэх зорилтыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр дэмжиж жендэрийн тэгш байдлыг хангах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхээр чармайн ажиллаж байна. Ази, Номхон далайн орнуудын үндэсний парламент дахь эмэгтэйчүүдийн тоо 1995 оноос хойш аажмаар буюу жилд дунджаар 0.5 хувиар өсч байна. Энэ байдлаар цаашид үргэлжилбэл НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтууд дэлхий нийтийн түвшинд 2025 оноос өмнө биелэхгүй бөгөөд зарим улсад үүнээс ч удах төлөвтэй. Түүнчлэн энэхүү үйл явцыг түргэсгэж, идэвхжүүлэх арга хэмжээ авахгүй тохиолдолд Ази, Номхон далайн бүс нутгийн хууль тогтоох байгууллагууд дахь жендэрийн тэгш байдал хагас зуун жил өнгөрсний дараа л биеллээ олох юм.

Ази, Номхон далайн бүс нутгийн сонгуульт албан тушаал дахь жендэрийн тэгш байдал. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх 6 зүйлт төлөвлөгөө хэмээх НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн энэхүү бүтээл нь Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнууд дахь эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийн ерөнхий дүр зургийг гаргахын зэрэгцээ сонгуульт албан тушаалд жендэрийн тэгш байдал бий болгоход чиглэгдсэн 6 зүйлт шинэчлэлийн үр нөлөө ямар байгааг авч үзлээ. Энэхүү түргэвчилсэн, шат дараалсан 6 арга зам буюу “боломж” гэдэгт заавал дагаж мөрдөх квот, үндсэн хуульд заасан эрх, улс төрийн намын гишүүнчлэл, чадавхийг бэхжүүлэх санаачлагууд, парламентын шинэчлэл зэрэг багтана. Зургаан зүйлт үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргахдаа улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхээр ажиллаж буй үндэсний бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч нар нөхцөл байдалдаа тохируулан эдгээр “боломж”-оос сонгох бололцоотой байхаар зохион байгуулав.

Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөө нь өөрийн улс орны нөхцөл байдлыг харгалзан улс төрийн тэгш байдлыг хангах стратегиа тодорхойлохыг хүсч буй Ази, Номхон далайн орнуудад зориулагдсан болно. Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмждэг улс төрийн нам, парламент, яам, иргэний нийгэм, олон улсын байгууллага, хөгжлийн байгууллагууд зэрэг бусад холбогдох талуудад ч ач холбогдолтой юм. Тус үйл ажиллагааны төлөвлөгөөнд улс төрийн тэгш байдалд хэрхэн хүрэх талаар чиглэл өгсөн хэдий ч эмэгтэйчүүд өөрсдөө урагш тэмүүлж, шийдвэр гаргах түвшинд оролцох эрхээ хамгаалах учиртай юм. Одоо байгаа нөлөө, нөөц бололцоо, үлгэр жишээ, дагуулан дэмжигч, гэр бүл, хамт олны дэмжлэгийг авч чадвал Ази, Номхон далайн орнуудад улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалттай түвшинд хүрэх боломж нээлттэй байна.

Жералдин Фрейзэр-Моликети
НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн
Ардчилсан засаглалын бүлэг/
Бодлогын албаны захирал

II. ХУРААНГУЙ

Шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангах зорилго нь нийгмийн шударга ёсыг хангаж, эмэгтэйчүүдийн чадавхи, мэдлийг нэмэгдүүлэх, хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, ардчилсан хууль ёсны байгууллагуудын хүлээн зөвшөөрөгдөх байдлыг бэхжүүлэхэд чухал байр суурь эзэлдэг.

Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хангах шаардлагын талаар олон улсын хамтын нийгэмлэг байнга анхаарч ирлээ. Бээжингийн тунхаглал, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн асуудлаарх олон улсын 4 дүгээр бага хурлын (1995) Мөрийн хөтөлбөрт эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн шийдвэр гаргах явцад эн тэнцүү оролцох замаар нийгэм, хувийн амьдралын бүхий л салбар дахь эмэгтэйчүүдийн идэвхтэй оролцоонд учруулж буй саадыг арилгах талаар улс орнуудын засгийн газрууд үүрэг амлалт авсан[1] билээ.

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцоор үүнийг дахин бататгасан. Чингэхдээ уг конвенцод нэгдэн орсон орнууд засаглалын бүх түвшинд, түүний дотор сонгуульт болон томилогдох албан тушаал, шүүх, төрийн албанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш, үр дүнтэй оролцоог дэмжих шаардлагатай бүхий л арга хэмжээ авахаар тогтсон. Эмэгтэйчүүдийн хувьд хүний эрхийг тэгш эдлэх нь олон нийт, хувийн амьдралын бүх салбарт бүрэн дүүрэн оролцож, иргэн, идэвхтэн, удирдагч байхад нэн чухал юм.

Түүнчлэн Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, бүх нийтийг хамарсан, тэгш, тогтвортой хөгжилд эмэгтэйчүүдийн манлайлал нэн чухал. Ази, Номхон далайн бүс нутаг боловсрол, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн бодлого, эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрхээс гадна гэр бүл, асран халамжлагч нарын асуудлаарх жендэрийн тэгш байдлыг хангахад томоохон сорилтуудтай тулгарсан хэвээр байна.[2] Зарим бэрхшээл эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд нь тохиолддог. Гэхдээ бүх насны эмэгтэйчүүдэд зарим бэрхшээл илүү хүнд тусдаг. Тухайлбал: газар, зээл, хангалттай цалинтай ажлын олдоц муу, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн ядуурал, жендэрээс үүдсэн хүчирхийлэл, нярай охидыг егүүтгэх асуудал, хүний наймаа, гэрлэлт ба өв залгамжлах эрхгүй байдал, шударга ёсны хүртээмж сул, түүнчлэн дайны хөлд нэрвэгдсэн газарт бэлгийн халдлага, хүчирхийллийн эрсдэл зэргийг дурдаж болно. Дэлхийн нийт хүн амын 51 хувийг шийдвэр гаргах үйл явцад

оролцуулаагүй тохиолдолд хөгжил үр дүнтэй байж чадахгүй. Шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүд бодлого тодорхойлоход ч мөн оролцоно.[3] Ярвигтай асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлого боловсруулах үйл явцад эмэгтэйчүүдийн дуу хоолойг сонссоноор харгалзан үзэх туршлага, үзэл бодол, чадварын цар хүрээ тэлдэг. Тал бүрийн туршлага, замнал, үзэл бодолтой гишүүдтэй хууль тогтоох байгууллага ерөнхийдөө илүү шинэлэг, ярвигтай асуудлыг шийдвэрлэхдээ "хайрцагнаас гадуур" шийдэл олдог. Бодлогын хэлэлцүүлэг, шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүд жирэмсний болон амаржсаны амралт, хүүхдийн халамж, гэр бүлд ээлтэй ажлын байр, тосгон суурингийн хөгжил зэрэг асуудлыг идэвхтэй дэмжиж сурталчилбал ач холбогдол нь нэмэгддэг. Энэтхэгийн жишээнээс харахад орон нутгийн зөвлөлд эмэгтэйчүүдийн төлөөлөл хүчтэй байх тохиолдолд эрүүл мэнд, хүний хөгжилд чухал ач холбогдолтой ус, ариун цэврийн чиглэлээрх хөрөнгө оруулалтыг дэмжихэд уг хүч, нөлөөллөө ашиглаж байсан нь ажиглагдсан.[4]

Эцэст нь тэмдэглэхэд нийгмийн бүх хэсгийг төлөөлсөн парламент нь төлөөллийн байгууллагын ардчилсан чанар, хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байдалд бэлэгдлийн чухал нөлөөтэй. Өргөн хүрээ хамарсан парламент иргэний, ардчилсан оролцоог бэхжүүлэх чадавхитай байдаг. Эмэгтэй удирдагч бусдад үлгэр болохын зэрэгцээ эмэгтэйчүүдийг сонгогч, намын гишүүн, улс төрийн идэвхтэн болгон зохион байгуулах чадвартай байдаг.[5] Иймд сонгуульт албан тушаал дахь эмэгтэйчүүд ардчилсан оролцоог бэхжүүлдэг.

Эдгээр учир шалтгааны улмаас НҮБ жендэрийн тэгш байдал, сонгуульт албан тушаал дахь эмэгтэйчүүдийн оролцоог хангахаар зорьж байна. Парламентад эзлэх эмэгтэйчүүдийн хувь хэмжээ дээрх зорилт хэр ахиж байгааг хэмжих нэг ерөнхий шалгуур юм. Үүнийг жендэрийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх Мянганы хөгжлийн 3 дахь зорилтыг улс орнууд хэрхэн хэрэгжүүлж буйг заах нэгэн хэмжүүр болгосон.[6] Гэсэн хэдий ч шийдвэр гаргах түвшний албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн тоо дээрх зорилтыг биелүүлэхэд хүндрэл гарсаар байгааг харуулж байна. 2011 оны 12 дугаар сарын байдлаар дэлхийн хэмжээнд парламентын (хоёр танхимтай бол доод танхим) суудлын 19.6 хувь нь эмэгтэйчүүдэд ноогдож байна. Энэ үзүүлэлт 1995 онд 11.3 хувь байжээ. Энэ нь хэдий бага ч гэсэн ахиц боловч зөвхөн 25 улс шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог 30 хувьд хүргэх тухай 1995 оны Бээжингийн тунхаглалын заалтыг хангажээ. Түүнчлэн зөвхөн 8 улсын парламент 40-60 хувийн тэнцвэрт байдалд хүрсэн байна. Үүний зэрэгцээ сонгуулийн хууль болон нэр дэвших, санал өгөх явцад эмэгтэйчүүдийг алагчлах явдал гарсаар байна. Олон улс орон жендэрийн тэгш байдлыг хангахад тулгарч буй саад тотгорыг арилгах санаачлага дэвшүүлэн ажиллаж байгаа боловч хэрэгжилтийн шатанд хүндрэл гарч байна.[7]

Ази, Номхон далайн бүс нутаг дотроо 2011 оны эцсийн байдлаар Азийн улс орнуудын парламентад эмэгтэйчүүд тавны нэг буюу 18.3 хувь эзэлж байна. Энэ нь 2000 оныхоос даруй 15 хувь өссөн үзүүлэлт юм. Номхон далайн арлын орнуудад энэ үзүүлэлт 13 хувьтай, дэлхийн дунджаас хоцорч байна.[8] Номхон далайн арлын орнуудын форумд багтах 13 парламент нийт 485 гишүүнтэйгээс

эмэгтэй гишүүн дөнгөж 17 аж.[9] Түүнчлэн Ази, Номхон далайн бүс нутаг дотроо нөхцөл байдал ихээхэн ялгаатай байна. Шинэ Зеланд (34 хувь), Балба (33 хувь), Зүүн Тимор (29 хувь), Вьетнам (24 хувь)-ын парламентын доод танхимд эмэгтэйчүүд нийт гишүүдийн 25-33.3 хувийг эзэлж байхад Тонга[10], Маршаллын Арлууд, Тувалу, Вануату, Папуа Шинэ Гвинейн үндэсний парламент тус тус нэг эмэгтэй гишүүнтэй. Соломоны Арлууд, Науру, Микронезийн Холбооны Улсад нэг ч эмэгтэй төлөөлөл парламентад байхгүй. Австрали, Шинэ Зеландыг эс тооцвол Номхон далайн бүс нутаг дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн түвшин Арабын улс орнуудаас бага буюу дэлхийн хамгийн багад тооцогдож байна.

Орон нутаг, муж, үндэсний түвшний хууль тогтоох байгууллагууд ирээдүйн удирдагчдыг бэлтгэх суурь болж өгдөг. Эмэгтэй төр, засгийн тэргүүнтэй улс орон дэлхийн хэмжээнд цөөн билээ. Өнөөгийн байдлаар дэлхийн 195 улсын 15 нь буюу 5 хувь нь эмэгтэй удирдагчтай байна. Азид эмэгтэйчүүд өндөр албан тушаалд ажиллаж байсан тохиолдол цөөнгүй бий. Тэдгээрээс олонд танигдсан жишээг дурдвал Бангладешийн Шейх Хасина Важэд, Бегум Халеда Зиа, Малайзын Ван Азиза Ван Исмайл, Мьянмарын Ан Сан Сү Чи, Индонезийн Мегавати Сукарнопутри, Пакистан Беназир Бутто, Филлипины Коразон Аквино, Глориа Макапагал-Арроёо, Шри Ланкийн Чандрика Кумаратунга, Энэтхэгийн Сониа Ганди нар юм. Тэд эрх баригчдын гэргий, охин байсан гэх зэргээр ихэвчлэн гэр бүлийн хэлхээ холбоонд тулгуурлан ерөнхийлөгч, ерөнхий сайд, сөрөг хүчний тэргүүн болжээ.[11] Мөн эмэгтэй удирдагчтай улс орнуудад засгийн газар, парламентын түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалттай нэмэгдээгүй байдаг. Ази, Номхон далайн бүс нутагт (Австрали, Шинэ Зеландыг тооцолгүйгээр) засгийн газрын эмэгтэй гишүүдийн эзлэх хувь 10 хүрдэггүй бөгөөд Монгол, Балба, Зүүн Тиморын засгийн газарт тус үзүүлэлт 20 гаруй хувьтай байдаг.[12] Орон нутаг, улсын хэмжээний сонгуульт албан тушаалд эмэгтэй гишүүний төлөөлөлгүй улс төрийн намууд эмэгтэйчүүдийг сайд, намын дарга, төр, засгийн тэргүүнээр томилон ажиллуулахад хүндрэлтэй байдаг.

Сонгуульт албан тушаал дахь жендэрийн тэгш бус байдлын шалтгаан: Хөгжил, соёл, тогтолцоо

Ази, Номхон далайн бүс нутагт яагаад ийм ялгаа гарч байна вэ? Тус бүс нутаг эдийн засгийн хөгжлөөр дэлхийд тэргүүлэхийн зэрэгцээ дэлхийн нийт ядуусын тал хувь энд амьдардаг. Энд эдийн засгийн шилжилтийн явцад байгаа Вьетнам, Монгол, Хятад, дэлхийн хамгийн том эдийн засаг болох Хятад, Энэтхэг, дундаж орлоготой орнуудад тооцогдох Вьетнам, Индонез, Малайз, Тайландаас гадна Афганистан, Зүүн Тимор Камбож, Индонези, Балба, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Тайланд, Соломоны Арлууд, Филиппин, Шри Ланк гэсэн зөрчил мөргөлдөөнтэй болон түүнээс ангижирч байгаа орнууд оршино. Эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлтийг харгалзан үзвэл Өмнөд болон Зүүн Азид төрсөн охидыг огт өөр амьдралын боломж угтаж байна.[13] Ази, Номхон далайн бүс нутагт орших нийгмүүд шашин шүтлэг, угсаатан зүй, каст, орлогын түвшин, ангийн байдлаар ялгарахаас гадна онцгой содон соёлын уламжлал, колончлолын түүхтэй байдаг. Түүнчлэн эдгээр улс орон үер ус, цунами, хар салхи, түймэр, галт

уулын тэсрэлт, газар хөдлөлтөөс үүдэн гарах хүмүүнлэгийн болон байгалийн гамшигт өртөх эрсдэлээрээ харилцан адилгүй.

Иймд Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнууд эдийн засаг, нийгмийн ижил бус нөхцлөөс хамааран хөгжлийн өөр өөр зорилтыг дэвшүүлдэг. Бүх нөхцөл байдалд таарах нэг шийдэл гэж байхгүй. Гэвч эдгээр улс орнууд жендэрийн тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийн оролцоог бэхжүүлэх нийтлэг сорилттой тулгараад байна.

Хөгжил

Эмэгтэй улс төрч цөөн байгаагийн шалтгааныг хүний хөгжлийн үр нөлөөтэй холбон тайлбарлах нь түгээмэл. Хөгжиж буй улс орны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад боловсрол, бичиг үсэг тайлагдсан байдал, цалинтай ажиллах хүчний оролцоо нь ихэвчлэн сул байдаг.[14] Хөгжил ерөнхийдөө эмэгтэйчүүдийн сургуульд суралцах хугацаа уртасгаж, эрүүл мэндэд эерэгээр нөлөөлөхийн зэрэгцээ төрөлт буурч, улмаар хүүхэд асрахад зарцуулах хугацаа багасахад хүргэдэг. Хүний хөгжлийг дэмжих нь нэн чухал. Гэвч улс орнуудад нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) хэмжээ ихэсч, охидын сургуульд хамрагдах түвшинг дээшлүүлж, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг хангаж, дундаж наслалтыг уртасгах зэрэг хөгжлийн чухал зорилтоо биелүүлсэн хэдий ч шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлээгүй байх тохиолдол гардаг. Энэ талаар Дэлхийн жендэрийн ялгааны 2011 оны тайланд дурдсан байдаг. Дэлхийн хамгийн чинээлэг, аж үйлдвэржсэн орон болох Японы парламентын гишүүдийн дөнгөж 11.3 хувь нь эмэгтэй бөгөөд Япон энэ үзүүлэлтээрээ 2011 оны эцсийн байдлаар дэлхийд 106-д жагсаж байна. Орон нутаг, мужийн түвшинд эмэгтэй гишүүд 8 хувийг эзэлж байна.[15] Үүнтэй адилаар Бүгд Найрамдах Солонгос Улсын парламентын 14.7 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж, дэлхийд 87-д жагсаж байна. Харин дэлхийн хамгийн ядуу орнуудын нэг Афганистаны парламент - Волиса жиргагийн гишүүдийн 28 хувь эмэгтэй (дэлхийд энэ үзүүлэлтээр 30-д орж байна). Одоогийн байдлаар парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хамгийн өндөр хувь буюу 56 хувьд буурай хөгжилтэй орнуудын нэг болох Руандагийн парламент хүрсэн байна.

ЗУРАГ 1 **Жендэртэй холбоотой хөгжлийн хязгаарлалтууд**

Ази-Номхон далайн бүс

- Номхон далайн бүс
- Зүүн Ази
- Өмнөд Ази
- Зүүн-Өмнөд Ази
- Австрали

Тэмдэглэл: *Жендэртэй холбоотой хөгжил нь Хүний хөгжлийн индексийн үндсэн үзүүлэлтүүдтэй адил байна. Үүнд: наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ногдох ДНБ багтана. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хүрсэн амжилт тэгш бус байгааг анхаарах.*

Эх сурвалж: *Олон улсын Парламентын холбоо, Үндэсний парламент дахь эмэгтэйчүүд (2010 оны 10 дугаар сарын байдлаар); Хүний хөгжлийн тайлан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, 2007 он http://hdr.undp.org/en/statistics/indices/gdi_gem/.*

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Жендэрийн хөгжлийн индексийг (ЖХИ) ашиглан өргөн хүрээний харьцуулалт хийж болно. Энэ нь Хүний хөгжлийн индексийн адил дундаж наслалт, боловсрол, бичиг үсэг тайлагдалт, нэг хүнд ногдох ДНБ зэрэг үндсэн үзүүлэлтүүдэд гарч буй ахицыг хэмжихээс гадна эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш бус байдлыг тусгадаг. Зураг 1-ээс харахад Ази, Номхон далайн бүс нутагт Жендэрийн хөгжлийн индекс болон сонгуульт албан тушаал дахь эмэгтэйчүүдийн харьцаа гэсэн хоёр үзүүлэлтийн хооронд системтэй хамаарал ажиглагдахгүй байна. Ийм учраас Ази, Номхон далайн бүс нутагт эмэгтэйчүүдийн төлөөллийг хангахад хүний хөгжил шаардлагатай хийгээд хангалттай хүчин зүйл биш юм.

Ардчилал ба ардчилах явц

Ардчилах үйл явц жендэрийн тэгш байдал, хүний эрхийг бэхжүүлж, нээлттэй, шударга сонгуулийн өрсөлдөөнийг дэмжиж,

эмэгтэйчүүдийг идэвхжүүлж, зохион байгуулагдах боломжийг өргөжүүлдэг гэж ойлгох нь их байдаг. Гэвч энэ бол нарийн төвөгтэй асуудал бөгөөд ардчилсан Үндсэн хууль баталж, сонгуулийн тогтолцоог өөрчилснөөр квот, суудал хадгалах заалтыг үгүй хийх тохиолдол бий. Тухайлбал, Монгол зэрэг Зөвлөлтийн тойрон хүрээлэлд багтаж байсан орнуудад өөрчлөлт шинэчлэл эхэлж, парламентын эрх мэдэл ихэсч, хараат бус болох үйл явцтай зэрэгцэн сонгуульт албан тушаал дахь эмэгтэйчүүдийн тоо буурсан билээ.

ЗУРАГ 2 **Ардчилсан үйл явц ба эмэгтэйчүүдийн төлөөлөл**



Тэмдэглэл: *Либерал ардчиллын түвшинг Фридом Хаусын 2010 оны иргэний эрх чөлөө, улс төрийн эрхийн хэмжүүрээр тогтоов. 100 хүртэлх оноогоор.*

Эх сурвалж: *Олон улсын Парламентын холбоо, Үндэсний парламент дахь эмэгтнйчүүд (2010 оны 10 дугаар сар); www.freedomhouse.org*

Фридом хаусын мэдээллээр Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын парламентын доод танхимд эмэгтэйчүүдийн эзлэх хувь тухайн улсын ардчиллын түвшинтэй урвуу хамааралтай байгааг Зураг 2 харуулж байна. Ардчилах үйл явцын ач холбогдол өндөр боловч ялангуяа ардчилсан шилжилт эхлээд удаагүй байх үед эмэгтэйчүүдийн төлөөлөл автоматаар нэмэгдэхгүй харин буурах талтай.[16] Нэг намын тогтолцоотой коммунист улс болох Хятад, Вьетнамын үндэсний хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн тоо ардчилсан улсууд болох БНСУ, Энэтхэгийнхээс 2 дахин их байна.

Соёл

Соёлын уламжлалт *хандлага, үнэлэмж* нь эмэгтэйчүүдийг сонгуульт албан тушаалд дэвших эрмэлзлэлийг хавчих (нийлүүлэлт талдаа), эсвэл тэднийг алагчлах (эрэлт талдаа) замаар жендэрийн тэгш байдал бүрдүүлэхэд саад болох нь бий. Соёл бол аливаа нийгмийн зонхилох хэм хэмжээ, үнэлэмж юм. Тиймээс соёл жендэрийн үүрэг хариуцлагын талаарх хандлагыг тодорхойлж байдаг. Зарим нийгэм, нийгмийн хэсэг эмэгтэйчүүд гол төлөв өрх гэрээ асран халамжлах, эрэгтэйчүүд орлого олж, удирдан залах гэх мэтээр тэдний үүрэг роль ангид байх ёстой гэж үздэг. Харин эрх тэгш байдлыг дээдэлдэг нийгэмд жендэрийн үүргийг харилцан солих боломжтой гэж үздэг. Соёлын үнэлэмжийг ихэнхдээ нийгмийн судалгааны тусламжтайгаар тодорхойлно.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэгт харьцангуй эрх тэгш ханддаг нийгэмд эмэгтэйчүүд сонгогдох боломж илүү байдгийг нотолсон[17] судалгаа олон бий. Зураг 3-т үзүүлснээр Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудад улс төр дэх эмэгтэйчүүдэд хандахдаа соёлын уламжлалт хандлагыг баримтлах нь давамгай хэвээр байна. Иймд соёлын хандлага болон эмэгтэйчүүдийн парламентад орж ажиллах явдлын хооронд хамаарал байгаа нь илэрхий юм. Дэлхийн үнэлэмжийн судалгааг Ази, Номхон далайн бүс нутагт хэд хэдэн удаа хийсэн байдаг. Улс төр, ажлын байр, гэр бүлийн түвшин дэх жендэрийн тэгш байдалд хандах хандлага эдийн засгийн хөгжлийн ижил түвшинтэй, соёлын нийтлэг уламжлалтай улс орнуудад ч харилцан адилгүй байгааг тус судалгааны дүн харуулж байна.[18]

Соёлын үнэлэмжид олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, албан боловсролын тогтолцоо нөлөөлдөг бөгөөд энэ талаар дараагийн хэсэгт авч үзэх болно. Энэ хоёр хүчин зүйлийн аль аль нь жендэртэй холбоотой хэвшмэл ойлголт үүсгэж ч чадна, үгүй хийж ч чадна. Аж үйлдвэржилтийн дараах үед нийгэм шилжиж, боловсролын түвшин нэмэгдэж байгаа нь жендэрийн тэгш байдлын эерэг хандлага бүрдэхэд аажмаар нөлөөлж байна. Хэдий чухал боловч нийгэмд гүн гүнзгий шингэсэн үнэлэмжийг өөрчлөх нь хэцүү бөгөөд богино хугацаанд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй юм.

ЗУРАГ 3 **Уламжлалт соёл, ёс заншлаас үүдэлтэй хязгаарлалтууд**



Эх сурвалж: *Олон улсын Парламентын холбоо, Үндэсний парламент дахь эмэгтэйчүүд, (2010 оны 10 дугаар сарын байдлаар) http://www.ipu.org/wmn-e/classif.htm; Дэлхийн үнэлэмжийн судалгаа /World Values Survey/ 2005-7*

Тогтолцоо

Дээр дурдсан хүчин зүйлстэй харьцуулахад *тогтолцооны орчин нөхцөл*, ялангуяа орон нутаг, үндэсний хэмжээний сонгуульт албан тушаалд нэр дэвшигчдийг тодруулах үйл явц нь шинэчлэлийг түргэвчлэх хамгийн зохистой хэлбэр юм. Тогтолцоо гэдэгт шийдвэр гаргах албан тушаалд нэр дэвших, томилох, сонгох үйл явцыг зохицуулсан үндсэн хууль, бусад хууль, тогтоомжийг хэлнэ. Мөн энэ нь үндэсний, мужийн, орон нутгийн түвшин дэх ардчилсан засаглалын институтыг бэхжүүлэх хүчин чармайлтад дэм болж өгдөг.

ЗУРАГ 4 Нэр дэвшигчийг сонгох явц



ЗУРАГ 5 Сонгуульт албан тушаалд жендэрийн тэгш байдлыг дэмжих зургаан зүйлт үйл ажиллагааны төлөвлөгөө

1. ҮНДСЭН ХУУЛИАР ОЛГОГДСОН ЭРХ

Эрэгтэй, эмэгтэй хүмүүст иргэний тэгш эрхийг эдлүүлэх, түүний дотор сонгуульд оролцох, нэр дэвших болон эрхийг хангах.

2. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Сонгуулийн тогтолцоог шинэчлэх: Сонгуулийн тойрог нь том, пропорциональ тогтолцоотой бол эмэгтэйчүүдийн сонгогдох боломж нэмэгдэнэ.

3. ХУУЛИАР КВОТ ТОГТООХ

Бүх улс төрийн намын нэр дэвшүүлэх үйл явцыг зохицуулж буй хуулийг эргэн харах, Эмэгтэй гишүүдэд суудал хуваарилах, нэр дэвшигчдэд квот тогтооож өгөх нь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлнэ.

4. НАМЫН ДҮРЭМ БА НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ

Намын нэр дэвшигчийг тодруулах дотоод журмыг хянан үзэх, Нэр дэвшигчдийн жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн стратегийг квот, намын дотоод дүрэм, журамд заасан зорилтот түвшинд хангах замаар хэрэгжүүлнэ.

5. ЧАДАВХИ БЭХЖҮҮЛЭХ

Сонгуульт албан тушаалд ажиллах эмэгтэйчүүдийн ур чадвар, нөөц бололцоог дээшлүүлэх. Үүнийг улс төрийн намууд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн бус байгууллага санаачлан хийж болох бөгөөд мэдээлэл, мэдлэгийн сүлжээ, дагуулан сургах хөтөлбөр, ур чадвар олгох сургалт, эмэгтэй нэр дэвшигчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэх мэт ажиллагаа багтаж байна.

6. ПАРЛАМЕНТЫН ШИНЭЧЛЭЛ

Парламентын үйл ажиллагааны дотоод дүрэм журамд өөрчлөлт шинэчлэл хийх. Үүнд: гишүүдийн ажиллах орчин, нөхцлийг харгалзан ажлын цаг, чуулганы өдрийг зохицуулах, удирдах албан тушаалд сонгон ажиллуулах зарчмыг тодорхойлох, мөн хүүхэд асрах боломж, бололцоог гаргах гэх мэт.

Үйл ажиллагааны төлөвлөгөө

Үндсэн хуульд заасан эрхээс эхлэн сонгуульт албан тушаал хаших хүртэлх нэр дэвшигчийн дамжих шатлалыг Зураг 4-т дүрслэв. Харин Зураг 5-д Ази, Номхон далайн бүс нутгийн сонгуульт албан тушаалд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн тогтолцооны шинэчлэлийн зургаан зүйлт үйл ажиллагааны төлөвлөгөөг үзүүлэв.

(I) ҮНДСЭН ХУУЛИАР ОЛГОГДСОН ЭРХ: Жендэрийн тэгш байдлыг хангах хамгийн ерөнхий, суурь орчинг Үндсэн хуульд заасан эмэгтэйчүүдийн улс төр, иргэний эрх бүрдүүлдэг. Энэ нь ялангуяа сонгох, сонгогдох эрх, нийтийн албанд ажиллах эрх болон хүйсээр алагчлах аливаа хэлбэрийг устгах, иргэдийн тэгш байдалд учруулах саадыг арилгах зэрэгт хамаатай юм.[19]

(II) СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО БА УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ: Үндэсний, орон нутгийн, олон улсын сонгуульт албан тушаалд нэр дэвших болон сонгогдох үйл явцыг сонгуулийн тухай хууль болон улс төрийн намын тухай хуулиар зохицуулдаг. Үүгээр зохицуулах хамгийн гол асуудал бол сонгуулийн тогтолцоо бөгөөд пропорциональ, мажоритар, холимог хэлбэрийн аль нь болохоос шалтгаалан намууд нэр дэвшигчээ сонгоход өөр өөр боломж, хөшүүрэг үүсч байдаг. Сонгуулийн хуулинд тусгагдах дараах хүчин зүйлс эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөлнө. Үүнд суудал хадгалах, намын нээлттэй ба хаалттай жагсаалт ашиглах, сонгуулийн тойргийн хэмжээ (мандатын тоо), нам, нэр дэвшигч, сонгуулийн сурталчилгааны санхүүжилт, хуваарилалт дахин сонгогдоход тавих хязгаарлалт, нэр дэвшигчид тавих шаардлага, жижиг нам, бие даан нэр дэвшигчид боломж өгөх босго зэрэг багтана. Номхон далайн бүс нутагт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал байж болох ч тэр бүр дурдагддаггүй нэгэн зүйл бол хууль тогтоох байгууллагын хэмжээ юм. Энэ бол мөн л Үндсэн хуулиар эсвэл сонгуулийн тогтолцооны өөрчлөлт шинэчлэлээр хийдэг арга хэмжээ юм. Жижгэвтэр парламент ихэвчлэн цөөн тооны эмэгтэй гишүүнтэй байдаг.

(III) ХУУЛИАР КВОТ ТОГТООХ: Сүүлийн жилүүдэд хууль тогтоох байгууллага төдийгүй нийтийн алба хаагч, шүүгчийн албан тушаалд эмэгтэйчүүд нэр дэвшиж, сонгогдохыг хөнгөвчлөх үүднээс суудал хадгалах болон хуулиар нэр дэвшигчийн квот тогтоох аргыг ашиглахыг тусгайлан анхаарах болсон. Эдгээр арга хэмжээ нь эмэгтэйчүүдийн төлөөллийн зорилтот түвшин, байршлын дараалал заах эсэх, мөн хэрэгжилтэд хяналт тавих, биелүүлээгүй бол аливаа шийтгэл оноох эсэх зэргээрээ ялгаатай байдаг.

(IV) НАМЫН ДҮРЭМ: Улс төрийн намууд сонгуульт албан тушаалд нэр дэвшүүлэх өөрийн гэсэн албан ба албан бус практик, дотоод журам, хэвшсэн горимтой байдаг. Эмэгтэй нэр дэвшигчийн тоог нэмэх үр дүнтэй арга гэвэл нам дотроо жендэрийн сайн дурын квот тогтоох, албан бус зорилтот түвшинг тодорхойлон ажиллах, түүнчлэн намын дотоод бүтэц дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зэргийг дурдаж болно.[20]

(V) ЧАДАВХИ БЭХЖҮҮЛЭХ: Олон улсын байгууллага, эмэгтэйчүүдийн асуудал

эрхэлсэн яам, Засгийн газрын жендэрийн тэгш байдлын хороо, тэгш боломжийн төлөөх байгууллага, улс төрийн нам, эмэгтэйчүүдийн бүлгэм, иргэний нийгмийн сүлжээ зэрэг олон байгууллага чадавхи бэхжүүлэх үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжтой. Тогтолцооны түвшин чадавхи бэхжүүлэх ерөнхий асуудлаас гадна ирээдүйн эмэгтэй удирдагчдын чадавхийг бэхжүүлж, сонгуульт албан тушаалд эхлэн ажиллаж буй эмэгтэйчүүдийн туршлага, чадвар, мэдлэгийг өргөжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн санаачлага бий. Эдгээр арга хэмжээг өөр хоорондоо ялгаатай боловч зарим талаар давхардсан болно. Үүнд: *тэгш боломжоор хангах санаачлага* (нэр дэвшигчдэд сургалт явуулах, бэлтгэх, элсүүлэх арга хэмжээ авах, мэдлэгийн сүлжээ байгуулах гэх мэт), хэвшмэл ойлголтыг эвдэж, ойлголт нэмэгдүүлэх санаачлага (нэр дэвшсэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоо мэдээж судалж, статистикийн газар, олон талт байдлыг хянах газар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, иргэний боловсролоор дамжуулан мэдээлэх), *улс төрийн намын санаачлага* (намын мөрийн хөтөлбөр, эмэгтэйчүүдийн бүлэг, санхүүжилт авдаг эмэгтэйчүүдийн нам) багтана. Ялангуяа нэр дэвшигчдэд зориулсан сургалт бол сонгуулийн өмнө авдаг хамгийн түгээмэл арга хэмжээний нэг. Гэхдээ үр дүн нь сургалтын давтамж, үргэлжлэх хугацаа, сургалтаар олгох мэдлэг, чадварын хэлбэр, суралцагчаас ихээхэн хамаарна.

(VI) ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ПАРЛАМЕНТ: Эцэст нь хэлэхэд хууль тогтоох байгууллага бол стандарт дүрэм, үйл ажиллагаа явуулах журамтай бөгөөд тэр нь шийдвэр гаргах, удирдах түвшинд эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангахад саад болж болзошгүй. Иймд хууль тогтоох байгууллага нь жендэрийн асуудлыг бодлогод тусгах, парламентад удирдах албан тушаалд сонгон шалгарч парламентын хуралдааны хугацаа, хүүхдээ асрах эхчүүдэд зориулсан байгууламж зэрэг жендэрийн мэдрэмжтэй асуудлыг тусгах зорилгоор дотоод журмаа эргэн харах шаардлагатай.

Сонгуульт албан тушаал дахь жендэрийн тэгш байдлыг хангахад бүх улс оронд тохирох шийдэл гэж байхгүй. Мөн авах арга хэмжээ, хатуу тогтсон дараалал ч байхгүй. Сонгуульт болон томилгоот албан тушаалд ажиллах боломжийг эмэгтэйчүүдэд нээсэн үр дүнтэй арга нь тухайн орчин нөхцөлд л тохирсон арга хэмжээ юм. Зураг 6-д шийдвэрийн мод нь гол гол хувилбарыг харуулсан бөгөөд шинэчлэл хийхэд аль нь хамгийн үр дүнтэй гэдгийг тухайн улсын холбогдох талууд сонгоно.

ЗУРАГ 6 Шийдвэрийн дараалал: Сонгуульт албан тушаалд жендэрийн тэгш байдлыг бататгах үе шат/алхмууд

1-Р ҮЕ ШАТ. ҮНДСЭН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТУХАЙ ЯРИА ӨРНӨЖ БАЙНА УУ?

- ҮГҮЙ: Хэрэв үгүй бол тийм яриаг хэлэлцээг эхлүүлж чадах уу? Эсвэл...
- ТИЙМ: Хэрэв тийм бол Үндсэн хуулиар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрх баталгаажиж байна уу?
  - ҮГҮЙ: Хэрэв үгүй бол Үндсэн хуулийг хэрхэн шинэчилж болох вэ?
  - ТИЙМ: Хэрэв тийм бол эдгээр эрх нь бодит амьдрал дээр хэрэгжиж байна уу? Хэн эдгээр эрхийн хэрэгжилтийг хянаж байна вэ?

2-Р ҮЕ ШАТ. СОНГУУЛИЙН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР ЯРИА ӨРНӨЖ БАЙНА УУ?

- ҮГҮЙ: Хэрэв үгүй бол яриаг өрнүүлж болох уу? Эсвэл...
- ТИЙМ: Хэрэв тийм бол та пропорциональ системийг/төлөөллийг бүх тойрогт эсвэл заримд нь ашиглах сонгуулийн хуулийг дэмжиж чадах уу?
  - ҮГҮЙ: Хэрэв үгүй бол сонгуулийн хуулийг хэрхэн шинэчилж болох вэ?
  - ТИЙМ: Хэрэв тийм бол суудлын хэдэн хувийг пропорциональ төлөөлөл эзэлж болох вэ? Тэдний тойргийн дундаж хэмжээ (тойрогт ногдох гишүүний тоо) ямар байх вэ?

3-Р ҮЕ ШАТ. ЖЕНДЭРИЙН КВОТ ТОГТООХ ХУУЛЬ БАТЛАХ ТУХАЙ ЯРИА ӨРНӨЖ БАЙНА УУ?

- ҮГҮЙ: Хэрэв үгүй бол яриаг өрнүүлж болох уу? Эсвэл...
- ТИЙМ, Сонгуулийн мажоритар системээр. Хэрэв тийм бол сонгуулийн хуулиар эмэгтэйчүүдэд суудал хуваарилж тогтоож байна уу?
  - ҮГҮЙ
  - **ТИЙМ**: Тийм бол үүнийг бодит амьдрал дээр хэрэгжүүлж байна уу? баримтлан, зэрэг зиндаг харгалзан, мөрдөөгүй
- ТИЙМ, Сонгуулийн бүх эсвэл зарим нь пропорционалиар. Хэрэв тийм бол сонгуулийн хуулиар жендэрийн квот байна уу?
  - ҮГҮЙ
  - **ТИЙМ**: Тийм бол үүнийг шударгаар хэрэгжүүлж байна уу? бол шийтгэл хүлээлгэн хэрэгжүүлж байна уу?

4-Р ҮЕ ШАТ. ТАНЫ ӨӨРИЙН НАМЫН ДОТООД ӨРНӨЖ БУЙ ҮЙЛ ЯВЦ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ НАМЫН ҮНДСЭН ДҮРЭМ, ЖУРАМ, НЭР ДЭВШИГЧИЙГ СОНГОХ ҮЙЛ ЯВЦАА ШИНЭЧЛЭХЭД ХАНДУУЛЖ БАЙНА УУ?

- ҮГҮЙ: Үгүй бол яриа өрнүүлж болох уу? Эсвэл...
- **ТИЙМ**: Тийм бол нэр дэвшүүлэх тухай намын дотоод журам дахь бүх албан тушаал нэрээр нэр дэвшүүлэхэд жендэрийн квотыг ашиглана гэж тусгайлан заасан уу?
  - ҮГҮЙ
  - **ТИЙМ**: Тийм бол дүрэм журам бат мөрдөгдөж, зөрчсөн бол Шийтгэл хүлээж байна уу?

5-Р ҮЕ ШАТ. СОНГОГДСОН АЛБАНД ГОРИЛОГЧ, НЭР ДЭВШИГЧДИЙН ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМЫН ТАЛААР ЯРИА ӨРНӨЖ БАЙНА УУ?

- ҮГҮЙ: Хэрэв үгүй бол яриа өрнүүлж болох уу?
- **Эсвэл ...**
- **ТИЙМ**: Тийм бол нэр дэвшигчдэд зориулсан мэдээ, мэдээллийн сүлжээ, сургалтын байгууллагууд, хөтөлбөр, кампанит ажлаа санхүүжүүлэх татаас зэрэг арга хэмжээнүүд байна уу?

6-Р ҮЕ ШАТ. ПАРЛАМЕНТЫН ШИНЭЧЛЭЛИЙН ТУХАЙ ЯРИА ӨРНӨЖ БАЙНА УУ?

- ҮГҮЙ: Үгүй бол яриа өрнүүлж болох уу?
- ТИЙМ: Хэрэв тийм гишүүдийн ажиллах орчин хэрхэн ахлах, удирдах албанд сонгогдох тэгш боломж, мөн хүүхэд асрах боломж байна уу?

Мөргөлдөөнөөс ангижирч энхийг тогтоож байгаа эсвэл авторитар дэглэмээс шилжих шилжилтийн үйл явцад байгаа улс орнуудад шинэ Үндсэн хуулиндаа эмэгтэйчүүдийн эрхийг тусгах чухал боломж нээгддэг. Энэ замаар Афганистан, Зүүн Тимор, Балба улс парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллөөр бүс нутгийн бусад улстай харьцуулахад өндөр амжилт үзүүлээд байна.[21] Түүнчлэн сонгуулийн тогтолцоондоо жинтэй өөрчлөлт оруулж байгаа эсвэл төвлөрлийг сааруулж орон нутаг, мужийн хууль тогтоох байгууллага үүсгэн байгуулж байгаа улс орнууд дахь шинэчлэлийн өргөн хүрээтэй үйл явцын хүрээнд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх үр дүнтэй заалтуудыг тусгах боломж гардаг.[22]

Харин Үндсэн хуулийн зохицуулалт төлөвшсөн улс орнуудад хуулиар квот тогтоох, нам дотроо нэр дэвшигч тодруулах журмыг өөрчлөх, нэр дэвшигчдийн чадавхийг бэхжүүлэх санаачлага гаргах, сонгуульт албан тушаалтай холбогдолтой дүрэм, журмыг өөрчлөх кампанит ажил зохион байгуулах замаар шинэчлэл хийх боломж гаргаж болно. Мөн үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр байхгүй байсан ч улс төрийн намууд сонгуульт албан тушаалд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн тодорхой зорилт, зорилго бүхий өөрсдийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан ажиллах боломжтой.

Ази, Номхон далайн бүс нутагт улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог бэхжүүлэх боломжуудыг дүгнэж цэгнэх үүднээс энэхүү бүтэц тус бүс нутгийн улс орнууд дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн ерөнхий дүр зургийг гаргахын зэрэгцээ үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга замын үр нөлөөг авч үзэв. Баримт, эх сурвалжийг улс хоорондын харьцуулалт, олон нийтийн судалгаа, “өмнө” ба “дараах” хэлбэрийн жишээнээс бүрдүүлсэн болно. Энэхүү судалгаа нь дээрх хүчин зүйлсийн эерэг үр нөлөөг жишээгээр харуулахын зэрэгцээ арга хэмжээг хэрхэн авсан, яагаад зарим арга хэмжээ бусдаасаа илүү үр дүнтэй болсныг тодруулав. Төгсгөлд нь эдгээр аргыг хэрэгжүүлэх зорилгоор авах арга хэмжээг авч үзэв.

Chadari Foundation

III. АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН СОНГУУЛЬТ АЛБАН ТУШААЛ ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Эдгээр төрөл бүрийн арга хэмжээний үр нөлөөг ойлгохын тулд дэлхий хэмжээнд болон Ази, Номхон далайн бүс нутагт ажиглагдах ерөнхий зүй тогтол, чиг хандлагаар жишиг тогтоох шаардлагатай.

Улс төрийн төлөөлөл дэх жендэрийн тэгш байдалд гарч буй ахицыг хэмжих хамгийн энгийн шалгуур бол улс тус бүрийн парламентын доод танхимд эзлэх эмэгтэйчүүдийн хувь юм (2011 оны эцсийн байдлаар). Түүхэн баримт мэдээллийг тайлбарлахдаа болгоомжтой хандах шаардлагатай. Сонгуульт албан тушаал дахь эмэгтэйчүүдийн тоо бол эмэгтэйчүүдийн оролцоо, мэдэл гэсэн үг биш юм. Хууль тогтоох байгууллагууд чиг үүрэг, эрх мэдлийн хувьд ихээхэн ялгаатай байдаг. Жишээ нь Бутан, БНАСАУ, Лаосын парламентын бие даасан байдал эргэлзээ төрүүлдэг.[23] Парламент, конгресс, үндэсний ассамблей нэр төдий байх үед болон гүйцэтгэх засаглалаа хянаж, хууль санаачлах чадавхи дутмаг байх үед парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо бэлгэдлийн шинж чанартай байна. Гэсэн хэдий ч ийм парламентад ажиллаж буй эмэгтэй гишүүд туршлага хуримтлуулах боломжтой байдаг.

ЗУРАГ 7 **Ази, Номхон далайн орнуудын парламентын доод танхим дахь эмэгтэйчүүдийн хувь, 2010**



Эх сурвалж: *Олон улсын парламентын холбоо, "Парламент дахь эмэгтэйчүүд" 2010 он*

Зураг 7, Хүснэгт 1-д үзүүлснээр 2010 оны байдлаар парламентын доод танхим дахь эмэгтэйчүүдийн оролцооны түвшин Ази, Номхон далайн бүс нутгийн 40 улс орны хувьд ихээхэн зөрүүтэй байна. Энэхүү мэдээллийг гаргаснаас хойш Номхон далайн бүс нутагт 6 удаагийн сонгууль болсон нь тооны хувьд багахан өөрчлөлт оруулжээ. Балба, Шинэ Зеландын парламентын нийт суудлын гуравны нэгийг эмэгтэйчүүд эзэлж, энэ үзүүлэлтээр Ази, Номхон далайн бүс нутагт тэргүүлж байна. 2011 оны 5 сарын байдлаар Австрали, Афганистан, Зүүн Тимор, Лаост парламентын суудлын дөрөвний нэгийг, Вьетнамд 24.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Гэвч түгээмэл зүй тогтол ажиглагдахгүй байна. Эмэгтэйчүүдийн оролцоогоор тэргүүлэх улс орнууд өөр хоорондоо нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшин, ардчиллын туршлага, соёлын өв, газар зүйн байршлын хувьд ихээхэн ялгаатай байна. Харин жендэрийн тэгш бус байдал газар авсан улс орнуудын дунд нэгэн зүй тогтол 2010 онд ажиглагдаж эхэлсэн нь тэдгээр улс орон бүгд цомхон парламенттай, Номхон далайн жижгэвтэр улсууд байсан явдал юм.

ХҮСНЭГТ 1 Үндэсний парламентын доод танхимд сонгогдсон эмэгтэйчүүдийн хувь, Ази, Номхон далайн орнууд (1990-2010)

	1990	1995	2000	2005	2010	Өөрчлөлт	Суудал хадгалах	Хуульд квот заасан эсэх	Намын сайн дурын квот
Шинэ Зеланд	14	21	31	28	34	+20			
Балба	6	3	6	6	33	+27	Байгаа		
Зүүн Тимор				25	29			Байгаа	
Афганистан	4				27		Байгаа		
Австрали	6	10	22	25	27	+21			Байгаа
Вьетнам	18	19	26	27	26	+8			
Лаос	6	9	21	23	25	+19			
Сингапур	5	4	4	16	23	+18			
Пакистан	10	2	17	21	22	+12	Байгаа		
Тайвань					22		Байгаа		
Камбож		6	7	10	21				
Хятад	21	21	22	20	21	0		Байгаа	
Филиппин	9	9	11	15	21	+11	Байгаа		Байгаа
Бангладеш	10	11	9	2	19	+9	Байгаа		
Индонези	12	12	8	11	18	+6		Байгаа	Байгаа
БНАСАУ	21	20	20	20	16	-5			
БНСУ	2	2	4	13	15	+13			Байгаа
Тайланд	3	6	5	7	13	+10			Байгаа
Энэтхэг	5	8	9	8	11	+6			Байгаа
Япон	1	3	5	7	11	+10			
Малайз	5	8	10	9	10	+5			
Бутан	2	0	2	9	9	+7			
Самоа		4	8	6	8				
Фижи		4	11	9	7				
Мальдив	6	6	6	5	6	0			
Шри Ланка	5	5	5	5	5	0			
Крибати		0	5	5	4				
Монгол (*)	25	4	8	7	4	-21			
Вануату	4	2	2	4	4	0			
Маршаллын арлууд		3	3	3	3				
Мьянмар					3				
Тонга		3	0	0	3				
Папуа Шинэ Гвиней		0	2	1	1				
Бруней					0				
Микронези		0	0	0	0				
Науру		6	0	0	0				
Палау		0	0	0	0				
Соломоны арлууд		2	2	0	0				
Тувалу		8	0	0	0				
Бүгд	8	6	8	9	13	+5			

Тэмдэглэл: *УИХ-ын сонгуулийн тухай Монгол улсын хуульд заасан 20%-иас доошгүй нь эмэгтэй нэр дэвшигч байх болзлыг хангаагүй тохиолдолд СЕХ, тойргийн хороо нам, эвслийг бүртгэхээс татгалзана.*

Парламентдаа нэг ч эмэгтэй гишүүнгүй Науру, Микронез, Соломоны арлуудын өмнө хамгийн том сорилт тулгарч байна. Парламентын доод танхимын гишүүн зэрэг сонгуульт болон томилгоот албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх жин нь сайдын алба хашиж байгаа болон парламентын хоёр танхимтай улс орнуудын дээд танхимд эмэгтэйчүүдийн эзлэх жинтэй харилцан уялдаж байгааг харж болж байна.[24] Уялдаатай байх зэргээр жендэрийн тэгш байдлын бусад үзүүлэлтүүдийн хувьд ч улс хоорондын ялгаатай байдлыг ажиглаж болохоор байна.

ЗУРАГ 8 **Парламентын доод танхим дахь эмэгтэйчүүдийн хувь, Бүс нутгаар, 2010**



Эх сурвалж: *Олон улсын парламентын холбоо, "Парламент дахь эмэгтэйчүүд" мэдээлэл*

Зураг 8-д парламентын доод танхим дахь эмэгтэйчүүдийн дундаж хувийг Ази, Номхон далайн дэд бүсээр ангилан үзүүлэв. Үүнээс Номхон далайн улс орнууд дөнгөж 2 хувийн төлөөлөлтэйгээр ихээхэн хоцорч байгаа нь тод харагдаж байна. Иймээс энэ нөхцөл байдлыг нэн даруй анхааралдаа авах шаардлага гарч байна. Зүүн болон Өмнөд Ази дэлхийн дунджаас бага байгаа бол Зүүн өмнөд Ази харьцангуй сайн, Австрали Ази хоёр ардчилсан орнуудад эмэгтэйчүүдийн төлөөлөл хамгийн өндөр байна.

ЗУРАГ 9 **Эмэгтэйчүүдийн төлөөллийн хандлага, 1945-2010 оны хооронд, Дэд бүс нутгуудаар харуулбал:**



Тэмдэглэл: *Парламентын доод танхим эсвэл нэг танхимтай парламент дахь эмэгтэйчүүдийн хувь, 1945-2008 он.*
Эх сурвалж: *Олон улсын парламентын холбоо, "Парламент дахь эмэгтэйчүүд" мэдээлэл*

Тэгвэл юу өөрчлөгдөж байна вэ? Парламентын доод танхим дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн Ази, Номхон далайн дэд бүсээр ангилсан, урт хугацааны чиг хандлагыг Зураг 8-аас харахад мөн л өөрчлөлтийн зөрүүтэй дүр зураг илэрнэ. Зүүн Азийн бүс нутаг хэдий бага түвшнээс эхэлж, удаан урагшилж байгаа боловч дэлхийн II дайн дууссанаас хойш тогтвортой өсөлт үзүүлж байна. Өмнөд Ази олон жилийн турш өсч байснаа 1990-ээд онд огцом нэмэгдсэн байна. Австралази 1980-аад оноос эхлэн нэгэн хэвийн байдлаасаа салж, гэнэт өсчээ. Парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь дэлхийн хэмжээнд Ази, Номхон далайн бүс нутгийг тооцохгүйгээр 1950-1960 онуудад 5 болон түүнээс ч доогуур бага байж байгаад 2000 оны гэнэтийн өсөлтөд хүртлээ арван жил тутамд 1-2 хувиар л нэмэгдэж байв. Сонгуульт албан тушаал дахь эмэгтэйчүүдийн түвшин 1985 оноос хойш ажиглагдсан хурдаа (жилд 0.2 хувь) хадгалан ямар нэг хөндлөнгийн оролцоогүйгээр үргэлжлүүлэн өсөх аваас 150 орчим жилийн дараа парламент дахь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн харьцаа тэнцэх аж. Сүүлийн жилүүдэд ихээхэн ахиц дэвшил гарсан боловч дэлхийн хэмжээнд нийт хууль тогтоогчдын дөнгөж тавны нэг нь эмэгтэйчүүд байна. Энэ нь зарим улс шийдвэр гаргах түвшинд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангах талаар Бээжингийн тунхаглалд 10 гаруй жилийн өмнө тусгагдсан амлалтаа биелүүлээгүй байна гэсэн үг. Парламентын гишүүн төдийгүй төрийн

тэргүүн, Засгийн газрын тэргүүн, сайд, парламентын спикер, улс төрийн намын дарга зэрэг сонгуульт болон томилгоот улс төрийн бусад удирдах албан тушаалын хувьд ч эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс хоцорсон хэвээр байна.[25] Сонгуульт албан тушаал дахь эмэгтэйчүүд өндөр түвшний удирдах албанд бэлтгэгдэж байдаг тул парламентын сонгууль нь шийдвэр гаргах түвшний жендэрийн тэгш байдалд чухал нөлөөтэй юм.

ЗУРАГ 10 **1990-2010 оны хооронд зарим улс оронд гарсан өөрчлөлтийг шугаман үзүүлэлтээр харуулбал:**



Эх сурвалж: *Олон улсын Парламентын холбоо, "Парламент дахь эмэгтэйчүүд"-ийн мэдээллийн сан, 2010, http://www.pu.org*

Зөвхөн дэд бүсийн дунджуудыг авч үзвэл сүүлийн 20 жилд зарим улсад болсон анхаарал татахуйц өөрчлөлт орхигдох талтай (Зураг 10, Хүснэгт 1-ийг харна уу). 1990 болон 2010 оны үзүүлэлтийг харьцуулснаар Бангладеш, Балба, Лаос, Пакистан, Шинэ Зеланд зэрэг улсад тогтвортой эсвэл огцом өсөлт гарсныг ажиглаж болно. Гэвч зарим улсад ийм ахиц гарсангүй. Тухайн үед ардчилсан шилжилтийн үйл явцыг туулсан Монгол Улсад эмэгтэйчүүдийн оролцооны түвшин нэг намын тогтолцоот үеийн 25 хувиас 4 хувь болтлоо буурсан нь ихээхэн анхаарал татсан огцом өөрчлөлт юм. Богино хугацаанд

огцом өөрчлөлт гарах нь иэхэнхдээ квот тогтоох, арилгах, бүтцийн шинэчлэл хийх зэрэг түргэвчилсэн бодлого, арга хэмжээний дүн байдаг. Хүснэгт 1-ийн эхний улсууд буюу Ази, Номхон далайн бүс нутагт 2010 оны байдлаар парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингээр тэргүүлэх орнуудын дийлэнх нь квотыг Үндсэн хууль, хууль, намын дүрэмд тусгасан байна. Эсрэгээрээ сүүлийн 20-д жагсах улсуудын алинд нь ч квот байдаггүй.

ХҮСНЭГТ 2 Орон нутгийн парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь, Ази, Номхон далайн орнууд, 2010 оны 10 дугаар сарын байдлаар

	Хөдөө	Хот	Дүүрэг	Бүс нутгаар	Үндэсний хэмжээнд	Орон нутаг дахь хадгалсан суудал эсвэл хуулиар олгосон квотын байдал
Афганистан				30	27	Суудал хадгалдаг
Австрали		28		28	27	
Бангладеш	23	25	34		19	Суудал хадгалдаг
Бутан					9	
Бруней					0	
Камбож	15		13	10	21	
Хятад	22	48			21	
Фижи					7	
Энэтхэг	37		37	37	11	Суудал хадгалдаг
Индонези			12	14	18	Хуулиар квот тогтоосон
Иран					3	
Япон	8	12		8	11	
Кирибати	4	0			4	
БНАСАУ					16	
БНСУ		22		15	15	Хуулиар квот тогтоосон
Лаос					25	
Малайз					10	
Мальдив					6	
Маршаллын арлууд					3	
Микронези					0	
Монгол			28	16	4	
Мьянмар					3	
Науру					0	
Балба					33	Суудал хадгалдаг
Шинэ Зеланд				29	16	
Пакистан	31		33		22	Суудал хадгалдаг
Палау					0	
Папуа Шинэ Гвиней					1	Суудал хадгалдаг
Филиппин	30				21	Суудал хадгалдаг
Самоа					8	
Сингапур					23	
Соломоны арлууд		5		3	0	
Шри Ланка	2	3		4	5	
Тайвань					22	
Тайланд	13	13		13	13	
Зүүн Тимор					29	Суудал хадгалдаг
Тонга	1				3	
Тувалу	8				0	
Вануату	8			0	4	
Вьетнам	20			24	26	Хуулиар квот тогтоосон
Нийт дундаж	16	17	26	17	17	

Эх сурвалж: *НҮБХХ. 2010. Ази, Номхон далайн орнуудын орон нутгийн засаг захиргаан дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл, 2010. Бангкок хот, НҮБХХ.*

Эмэгтэйчүүд орон нутгийн засаг захиргаанд

Орон нутгийн эрх барих байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл чухал ач холбогдолтой. Учир нь орон нутаг, мужийн байгууллагууд нийгмийн үйлчилгээг хүргэдэг, мөн үндэсний түвшний удирдах ажилд ажиллах үүд хаалгыг нээж өгдөг. Хүснэгт 2-т орон нутаг, хот суурин, дүүрэг, хороо, бүс нутаг, үндэсний хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүдийн эзлэх хувийг харьцуулав. Мэдээлэл бүрэн гүйцэд биш байгаа ч ерөнхий зургаас нь ажиглахад Ази, Номхон далайн улс орнуудын нөхцөл байдал хоорондоо ялгаатай гэдэг нь дахин нотлогдож байна. Мөн эмэгтэйчүүдийн төлөөлөл сул байгаа нь зөвхөн үндэсний түвшинд биш гэдгийг харуулж байна. Тайланд, Шри Ланк, Японд Засгийн газрын бүх түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл сул байгаа бол суудал хадгалах квотыг ашигласантай холбоотойгоор Бангладеш, Пакистан, Энэтхэгт энэ байдал эсрэгээрээ буюу орон нутгийн түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл үндэсний түвшнийхээс өндөр байна.

Сонгогчдын дундах жендэрийн ялгаа

Сонгуульт албан тушаал дахь жендэрийн тэгш биш байдал нь сонгуульд оролцогчдын жендэрийн тэгш биш байдалтай харьцуулахад хамаагүй их юм гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Дэлхийн үнэлэмжийн судалгаа, Азийн барометр судалгаанд үндэслэн сүүлийн үед болсон үндэсний сонгуульд оролцогсдыг хүйсээр хуваан Хүснэгт 3-т үзүүлэв. Эмэгтэйчүүдийн сонгуулийн идэвх эрэгтэйчүүдийнхээс хол зөрдөггүй (3 хувийн зөрүүтэй) боловч Анхан шатны оролцооны жендэрийн тэгш биш байдал олон улсад ажиглагдаж байгааг харж болно. Дээрх хоёр судалгааны дүнгээс үзэхэд БНСУ, Вьетнам (Засгийн газрынх нь эх сурвалжид 99 хувь гэж дурдсан), Японд сонгогчдын жендэрийн ялгаа нэлээд өндөр байна. Дараалсан сонгуулийг хамруулсан өргөн хүрээтэй харьцуулалт хийхэд сонгогчдын дундах жендэрийн ялгаа аажмаар буурч, зарим тохиолдолд эмэгтэйчүүдийн идэвхи давамгайлж байна.[26] Иймд сонгуульт албан тушаал дахь жендэрийн тэгш бус байдлыг эмэгтэйчүүдийн сонгуулийн идэвхтэй шууд холбон тайлбарлаж болохгүй юм.

ХҮСНЭГТ 3 Сонгуульд санал өгсөн хүмүүсийн хүйсийн ялгаа Ази, Номхон далайн орнууд

Улс орнууд	Эрэгтэйчүүдийн хувь	Эмэгтэйчүүдийн хувь	Санал өгсөн хүмүүсийн хүйсийн ялгаа
Азийн барометр (АВ)			
Вьетнам	90	81	-9
Япон	89	82	-7
БНСУ	71	65	-6
Хятад	69	67	-2
Монгол	88	85	-3
Индонези	91	89	-2
Сингапур	63	61	-2
Малайз	60	59	-1
Тайланд	87	87	0
Филиппин	80	81	+1
Тайвань	82	83	+1
Азийн барометрийн дундаж	79	76	-3
Дэлхийн үнэлэмжийн судалгаа (WVS)			
Япон	80	72	-8
БНСУ	79	74	-5
Вьетнам	94	90	-4
Энэтхэг	93	90	-3
Малайз	55	52	-3
Индонези	92	90	-2
Тайланд	95	94	-1
Австрали	96	95	-1
Тайвань	74	77	+3
Дэлхийн үнэлэмжийн судалгааны дундаж	84	82	-3

Тэмдэглэл: *Өнгөрсөн сонгуульд саналаа өгсөн сонгогчдыг хүйсийн байдлаар харуулсан мэдээлэл*

Эх сурвалж: *Дэлхийн үнэлэмжийн судалгаа, 1981-2007 он*

Намын гишүүнчлэл дэх жендэрийн ялгаа

Улс төрийн үйл ажиллагаа идэвхтэй оролцоо шаардах тусам эмэгтэйчүүдийн оролцоо буурдаг гэсэн баримт бий. Хүснэгт 4-д Ази, Номхон далайн бүс нутгийн улс төрийн намын идэвхтэй ба идэвхгүй гишүүнчлэлийг харьцуулан үзүүлэв. Эндээс жендэрийн ялгаа өндөр байгаа хэд хэдэн тохиолдлыг харж болохоор байна. Бангладеш, Вьетнам, Индонези, Энэтхэгт эмэгтэйчүүд улс төрийн намд элсэх нь бага бол ялангуяа аж үйлдвэржсэн нийгэм болох Австрали, Шинэ Зеландад намын гишүүнчлэл дэх жендэрийн ялгаа бараг ажиглагддаггүй. Тиймээс эмэгтэйчүүд улс төрийн намын гишүүн байх нь байнга биш боловч ихэнх тохиолдолд сул гэж үзэх үндэслэл байна. Энэ ялгаатай байдал намууд эмэгтэй нэр дэвшигчийг тодруулахад саад болсоор байна.

IV. ҮНДСЭН ХУУЛЬ

Улс орнуудын сонгуульт албан тушаал дахь жендэрийн тэгш бус байдал ийм харилцан адилгүй байгаад юу нөлөөлж байна вэ? Олон хүн үүнийг улс төрийн байгууллагатай холбон тайлбарладаг. Хуулийн орчин, дүрэм журам үүнд нөлөөлдөг талаар хангалттай баримт судалгаа бий. Энэхүү “тоглоомын дүрмийг” бодлогын өөрчлөлт, шинэчлэлийн замаар өөрчлөх боломжтой. Жишээ нь үндсэн хуулиар дамжуулан эмэгтэйчүүдийн иргэний эрхийг хязгаарлан шууд, сонгуулийн тогтолцоо, сонгогдох болон томилогдох албан тушаалын тоо, түвшнийг заан шууд бусаар эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөлдөг.

Суурь түвшинд Үндсэн хуулийн заалтаар эмэгтэйчүүдийн иргэний эрх, түүний дотор хүйс харгалзалгүй санал өгөх, нийтийн алба хаших эрхийг хамгаалахаас гадна эмэгтэйчүүдийг алагчлахаас сэргийлэхэд чиглэсэн өмч, өв залгамжлал, газрын эзэмшил, иргэншил, гэрлэлттэй холбоотой, өргөн хүрээг хамарсан үндсэн эрх чөлөөг тусгаж өгдөг.[27] 1948 онд батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй”-г зарлан тунхагласан бөгөөд эдгээрийг 1979 оны Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын гишүүн 189 орны хүлээн зөвшөөрсөн конвенциор дахин нотолсон.[28] 1966 онд батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад бүс нутгийн орнуудын талаас илүү (40 улсаас 24) нь нэгдээд байна. Дээрх пактад Номхон далайн орнуудаас зөвхөн Австрали, Папуа Шинэ Гвиней, Соломоны Арлууд, Шинэ Зеланд нэгдэн оржээ. Олон улсын чанартай эдгээр гэрээ хэлэлцээрт тусгасны адилаар Ази, Номхон далайн орнууд Үндсэн хуулиар эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдийн адил сонгуульт албан тушаалд нэр дэвшиж, санал өгөх иргэний эрхийг олгоод байна.[29] Гэвч цаасан дээрх эрх амьдрал дээр хэрэгжихгүй байх тохиолдол гардаг. Түүнчлэн Үндсэн хуулийн өөрчлөлт нь эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн нэн чухал боломжийг нээдэг ч өв залгамжлал, гэр бүл салалт, газар өмчлөлтэй холбогдолтой эмэгтэйчүүдийн эрхийг боогдуулдаг шашны хатуу үнэлэмжийг дагах явдал бас бий. Эмэгтэйчүүд, цөөнхөд зориулан суудал хадгалах аргыг Үндсэн хуульд тусгаж болдог. Энэ талаар 5 дугаар бүлгээс харна уу.

ХҮСНЭГТ 4 Намын гишүүнчлэл дэх хүйсийн ялгаа, Ази, Номхон далайн орнууд

	Идэвхтэй гишүүд			Идэвх сул гишүүд			Намын гишүүн бус		
	Эрэгтэй	Эмэгтэй	**Ялгаа**	Эрэгтэй	Эмэгтэй	**Ялгаа**	Эрэгтэй	Эмэгтэй	**Ялгаа**
Бангладеш	17	3	**-14**	11	5	**-6**	72	92	**+20**
Вьетнам	21	7	**-14**	3	2	**-1**	77	92	**+15**
Энэтхэг	17	8	**-9**	31	27	**-4**	52	65	**+13**
Индонези	7	3	**-4**	15	9	**-6**	79	89	**+10**
Хятад	9	4	**-5**	10	5	**-5**	82	91	**+9**
Тайвань	3	1	**-2**	10	5	**-5**	87	93	**+6**
Малайз	7	3	**-4**	20	18	**-2**	74	79	**+5**
Филиппин	5	2	**-3**	5	4	**-1**	91	94	**+3**
Япон	3	1	**-2**	4	3	**-1**	93	96	**+3**
БНСУ	3	1	**-2**	7	5	**-2**	91	94	**+3**
Тайланд	7	6	**-1**	11	10	**-1**	83	84	**+1**
Австрали	3	1	**-2**	6	7	**+1**	91	92	**+1**
Шинэ Зеланд	2	2	**0**	12	13	**+1**	86	85	**-1**
Нийт дундаж	**8**	**3**	**-5**	**12**	**9**	**-3**	**81**	**88**	**+7**

Тэмдэглэл: *Намын гишүүнчлэлийг хүйсээр нь харуулсан мэдээлэл*
Эх сурвалж: *Дэлхийн үнэлэмжийн судалгаа, 1981-2007 он*

V. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Үндсэн хуульд тусгасан эмэгтэйчүүдийн эрх, суудал хадгалах зарчмаас гадна сонгуулийн тогтолцоо, мөн эмэгтэйчүүдийн төлөөлөлд нөлөөлж байдаг. Сонгогчдын саналыг хэрхэн илэрхийлэхийг зохицуулсан *санал хураалтын зохион байгуулалт*, төлөөлөлтэй болоход шаардлагатай саналын тоо, хувийг тогтоосон *босго үзүүлэлт*, *суудал хуваарилахад саналыг хэрхэн тооцохыг илэрхийлсэн сонгуулийн томьёо*, нэг тойрог хэдэн мандаттай байхыг заасан сонгуулийн тойргийн хэмжээ зэрэг сонгуулийн хуулийн чухал ач холбогдолтой заалтууд байдаг. Энэ бүтээлийн хувьд сонгуулийн тогтолцоог ерөнхийд нь мажоритар, холимог, пропорциональ буюу хувь тэнцүүлсэн гэж 3 ангилав. Мажоритар тогтолцоонд нэр дэвшигчдээс хамгийн их санал авсныг сонгох, их санал авсан нэр дэвшигчдийн дунд дахин санал хураалт явуулах, томсгосон тойрог, зөвхөн нэг санал өгөх, эсвэл эрэмбэлсэн санал өгөх зэрэг хувилбар багтдаг.[30] Мажоритар болон пропорциональ хэлбэрийг хамтад нь хэрэглэснийг холимог тогтолцоо гэнэ. Харин сонгуулийн пропорциональ тогтолцоонд намын жагсаалт болон нэг удаагийн шилжих саналын системийг ашигладаг. Ази, Номхон далайн бүс нутагт ашиглагдаж буй сонгуулийн тогтолцоог үзүүлсэн Хүснэгт 5-аас цөөн улс орон пропорциональ төлөөллийн системтэй байгааг харж болно.

ХҮСНЭГТ 5 Үндсэн хуулиар парламентад суудал хадгалахыг баталгаажуулсан байдал

	Үндсэн хууль баталсан эсвэл өөрчлөлт оруулсан он	Зүйл анги	Орон нутгийн парламент	Парламентын доод танхим	Парламентын дээд танхим
Афганистан	2004	Зүйл 83, Бүлэг 5	X	X	X
Бангладеш	2004[a]	Зүйл 65, Бүлэг 3	X	X	
Энэтхэг	1993		X		
Пакистан	2002[b]	Зүйл 51(1, 3)	X	X	X

Эх сурвалж: *Улс орнуудын Үндсэн хууль*

[a] *Тус улсын 1972, 1978, 1990 оны Үндсэн хуулиудын заалтуудаар Парламент дахь эмэгтэйчүүдийн суудлын тоог хадгалж баталгаажуулж байсан ба эдгээр заалт 10-15 жилийн дараа дуусч байсан.*

[b] *Тус улсын 1954, 1956, 1962, 1970, 1973, 1981, 1984 оны үндсэн хуулийн заалтуудаар Парламент дахь эмэгтэйчүүдийн суудлын тоог хуваарилж баталгаажуулж байсан байна.*

ХҮСНЭГТ 6 Парламентын доод танхимын сонгох сонгуулийн тогтолцоо (Ази, Номхон далайн орнууд)

Улсууд	Сонгуулийн тогтолцоо	Сонгуулийн төрөл	Үе шат	Гишүүдийн тоо (шууд сонгогддог)	Ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоо
Афганистан	SNTV	Бусад	1	249	TRS
Австрали	AV	Мажоритар	1	150	-
Бангладеш	FPTP	Мажоритар	1	345	-
Камбож	List PR	Пропорциональ төлөөлөл	1	123	-
Күүкийн арлууд	FPTP	Мажоритар	1	24	-
Тимор Лесте	List PR	Пропорциональ төлөөлөл	2	88	TRS
Фижи	AV	Мажоритар	2	71, 71	-
Энэтхэг	FPTP	Мажоритар	1	543	-
Индонези	List PR	Пропорциональ төлөөлөл	1	550	TRS
Кирибати	TRS	Мажоритар	1	40	FPTP
БНАСАУ	TRS	Мажоритар	1	687	-
БНСУ	Parallel	Холимог	2	299	FPTP
Лаос	BV	Мажоритар	1	109	-
Малайз	FPTP	Мажоритар	1	219	-
Мальдив	FPTP	Мажоритар	1	77	TRS
Маршаллын арлууд	FPTP	Мажоритар		33	-
Микронези	FPTP	Мажоритар	2	14	-
Монгол	MMP	Холимог	1	76	TRS
Мьянмар	FPTP	Мажоритар	1	485	-
Науру	BC	Бусад	1	18	-
Балба	Parallel	Холимог	1	205	-
Шинэ Зеланд	MMP	Холимог	2	120	-
Niue	FPTP	Мажоритар	2	20	-
Пакистан	Parallel	Холимог	2	342	-
Палау	FPTP	Мажоритар	1	16	TRS
Папуа Шинэ Гвиней	AV	Мажоритар	2	109	-
Филиппин	Parallel	Холимог	2	260	FPTP
Питкайрын арлууд	BV	Бусад	1	6	-
Самоа	FPTP	Мажоритар		49	-
Сингапур	PBV	Мажоритар		84	FPTP
Соломоны арлууд	FPTP	Мажоритар	1	50	-
Шри Ланка	List PR	Пропорциональ төлөөлөл	2	225	SV
Тайвань	Parallel	Холимог	2	113	FPTP
Тайланд	Parallel	Холимог	2	500	-
Того	TRS	Мажоритар	1	81	TRS
Тонга	BV	Мажоритар	1	9	-
Тувалу	BV	Мажоритар	1	15	-
Вануату	SNTV	Бусад	1	52	-
Вьетнам	TRS	Мажоритар	1	498	-

Кеу: *FPTP - Нэг мандаттай мажоритари; AV Alternative Vote-Альтернатив санал; SNTV - нэг удаагийн шилжүүлэх боломжгүй санал; BV Block Vote-Блок санал; TRS - Хоёр шаттай санал хураалт; Үл хамаарах холимог; MMP - Пропорцианалиар сонгогдсон холимог гишүүд, List PR - Пропорциональ төлөөлөл нэрсийн жагсаалтаар; PR - Пропорциональ төлөөлөл.*

Эх сурвалж: *Ардчилал, сонгуулийн туслалцааны Олон улсын хүрээлэн, Сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт, гарын авлага, http://www.idea.int/esd/world.cfm*

Парламентад сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо сонгуулийг намын жагсаалтаар буюу пропорциональ хэлбэрээр явуулахад мажоритар тогтолцооноос илүү их байсныг 1980-аад оны дунд үеэс хийгдэж эхэлсэн судалгаагаар баталжээ. Энэ хандлага хэд хэдэн ардчилсан болон хөгжиж буй орнуудын аль алинд нь ажиглагдаж байв.[31]

Холимог тогтолцоогоор сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин цэвэр мажоритар болон цэвэр пропорциональ тогтолцооны дундаж түвшинтэй ойролцоо байв.[32] Түүнчлэн тойрог олон мандаттай байх нь эмэгтэйчүүд сонгогдоход эерэгээр нөлөөлж байна.

Хүснэгт 6 дахь харьцуулалтаас Ази, Номхон далайн бүс нутагт сонгуулийн пропорциональ тогтолцооны хэрэглээ бага байгааг харж болох боловч ийм систем нэвтрүүлсэн Зүүн Тимор, Камбож, Индонези, Шри Ланкад парламент дахь эмэгтэйчүүдийн тоо сүүлийн 10 жилийн хугацаанд ерөнхийдөө ихэсчээ. 2010 оны байдлаар бүс нутгийн хэмжээнд сонгуулийн мажоритар тогтолцоотой улсуудад парламентын эмэгтэй гишүүд дунджаар нийт суудлын 8 хувийг эзэлж байв. Энэ үзүүлэлт холимог тогтолцоонд 16.3 хувь, хувь тэнцүүлсэн тогтолцооны хувьд 14.8 хувь байна.

Эмэгтэйчүүдийн пропорциональ тогтолцоонд (хувь тэнцүүлсэн санал хураалт бүхий холимог тогтолцоонд мөн адил) үзүүлж буй амжилтыг тайлбарлах гол зүйл нь олон мандаттай тойрогт намаас нэр дэвшигчдийг нэгдсэн жагсаалтаар танилцуулдагтай холбоотой. Иймд намууд сонгогчдын төлөөллийн бүх хэсгийг хамарсан байдлаар жагсаалтаа гарган олны дэмжлэгт нийцүүлэх сонирхолтой байдаг. Олон мандаттай тойрог жагсаалт дахь нийт нэр дэвшигчдийн өмнө хүлээх намын нэгдсэн хариуцлагыг нэмэгдүүлдэг. Намууд олон мандаттай тойрогт нэг хэсэг нэр дэвшигчийг “уралдуулах” болдог бөгөөд үүндээ эмэгтэйчүүд зэрэг нийгмийн томоохон хэсгийн төлөөллийг оролцуулахгүй бол алагчлал болон харагдаж, улмаар санал хураалтын дүнд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байдаг.

Харин хамгийн их санал авсан нь сонгогдогч мажоритар системээр нэг тойрогт, нэг суудлын төлөө өрсөлддөг. Нэр дэвшигчийг сонгох үйл явцыг орон нутгийн намын нэгж шийддэг тул тойрог, улс орны түвшинд “тэнцвэртэй” сонголт хийх сонирхол төрүүлдэггүй. Нам болон парламент дахь өргөн хүрээтэй үр дагаврыг харгалзалгүйгээр, тойрогтоо ялалтаа байгуулж, тухайн мандатыг намдаа авах хамгийн өндөр боломжтой нэр дэвшигчийг намын орон нутгийн гишүүд сонгодог.[33] Эрсдлээс зайлсхийж, боломжит хамгийн их санал авах рациональ стратегийн үүднээс парламентын өмнөх гишүүнтэй адил зан чанар, онцлогтой нэр дэвшигчийг сонгох нь түгээмэл байдаг.

Мөн сонгуулийн тогтолцооны хэлбэр нь парламентын гишүүн сонгогдох зүй тогтолд мөн нөлөөлж байдаг. Олонд танигдаж, хэвлэл мэдээллийн анхаарлыг татахаас гадна сонгуульт албан тушаалыг даган ирэх санхүүжилт, зохион байгуулалтын нөөц бололцоог ашиглах боломжтой тул парламентын гишүүнээр ажиллаж буй хүн дахин сонгогдох нь их байдаг. Энэ нь шинээр нэр дэвшигчдэд томоохон саад болдог.[34] Эмэгтэйчүүдийн хувьд намын дотор дэмжлэг авч нэр дэвшихээс гадна нэг мандаттай тойргийн хувьд ялах боломжтой тойрогт нэр дэвших эрх авах, мөн пропорциональ систем ашиглаж байгаа үед намын жагсаалтад дээгүүр байршихын төлөө

өрсөлдөх хэрэгтэй болдог. 1979-1994 онуудад ардчилал тогтсон 25 орны парламентын доод танхимын сонгуулиар гишүүдийн дунджаар гуравны хоёр нь дахин сонгогдсон, үүнээс пропорциональ тогтолцоонд 66 хувь, мажоритор тогтолцоогоор явагдсан сонгуулиар 70 хувь нь дахин сонгогдож байжээ.[35] Жишээ нь 1997 онд Их Британид Хөдөлмөрийн намын байгуулсан үнэмлэхүй ялалт болон эмэгтэйчүүдэд суудал олгох зориудын арга хэмжээний дүнд ИБУИНВУ-ын парламентын доод танхим дахь эмэгтэйчүүдийн тоо нэг дахин нэмэгдсэн байна. Уг зориудын арга хэмжээг дахин хэрэглээгүй ч Хөдөлмөрийн намын эдгээр эмэгтэй гишүүн 2001 оны сонгуульд дахин ялалт байгуулсан. АНУ-ын хувьд 1998-2000 оноос хойш дахин сонгогдоход хязгаар тогтоож, нээлттэй суудал бий болгосон мужуудад эмэгтэй нэр дэвшигчид илүү амжилттай өрсөлдсөнийг судлан тогтоожээ. Гэхдээ энэ нь өмнө нь цөөнгүй эмэгтэй гишүүнтэй байсан Калифорни зэрэг мужид сөргөөр нөлөөлсөн байна.[36]

Пропорциональ систем дэх намын жагсаалт нь нэр дэвшүүлэх явцад намын дотоодын болон хуульчлагдсан жендэрийн квот ашиглах зэргээр эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зориудын арга хэмжээ авахад дөхөм болдог. Ийм зориудын арга хэмжээг мажоритар системд хэрэгжүүлэх боломжтой ч нэг мандаттай тойрогт хэцүү байдаг.[37] Иймээс сонгуулийн пропорциональ тогтолцоо нь эмэгтэйчүүдэд ээлтэйд тооцогддог. Эдгээр шинж байдал холимог тогтолцоонд ч ажиглагддаг. Нэг мандаттай тойрог бий, Шинэ Зеландад эмэгтэйчүүд намын жагсаалтаар сонгогдох боломж илүү байгааг харуулсан.

Улс хоорондын ялгаанд нөлөөлөх сонгуулийн тогтолцоотой холбоотой бусад шалтгаанд тойргийн мандатын тоо, санал тооцох аргачлал, нам доторх өрсөлдөөн, намын үзэл суртал зэрэг хүчин зүйлс багтдаг. Ерөнхийдөө зүүний чиглэлийн намууд (Социалист, Социал демократ, Хөдөлмөрийн, Коммунист, Ногоон нам) жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн зориудын арга хэмжээг дэмжих нь илүү түгээмэл байдаг.[38]

N-Peace/Doungjun ROONGRUANG

VI. СУУДАЛ ХАДГАЛАХ БОЛОН ХУУЛИАР ТОГТООСОН КВОТ

Сонгуулийн тогтолцоо анхаарал татах болсноор эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор суудал хадгалах болон квот тогтоох зорилгоор Үндсэн хууль, сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах болжээ.[39] Энэ арга хэмжээ нь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн түгээмэл арга болж, 100 гаруй улсад хэрэглэгдэж байна.[40] Эмэгтэйчүүд, цөөнхөд зориулан хууль тогтоох байгууллагад суудал хадгалах шууд, шууд бусаар сонгож, томилдог; жендэрийн албан ёсны квот (тухай улс орны бүх намд хамааралтай); эсвэл дараагийн хэсэгт яригдах намын сайн дурын жендэрийн квот (тухайн намын дотоод дүрэм, нэр дэвшигч тодруулах үйл явцаар зохицуулагдсан) зэргээс шалтгаалан эдгээр арга хэмжээ өөр хоорондоо ялгардаг. Хүснэгт 7-д Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын квотын талаарх бодлогыг үзүүлэв.

ХҮСНЭГТ 7 Сонгуулийн тогтолцоо ба эмэгтэйчүүдийн төлөөлөл, Ази, Номхон далайн орнууд

	Парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь (2000)	Улс орны тоо	Парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь (2010)	Улс орны тоо
МАЖОРИТОР	7.9	23	10.5	21
Мандаттай тойрог	5.4	9	10.5	8
Блоколсон саналаар	6.8	4	8.7	4
Томсгосон тойрог	8.8	4	9.4	3
2 дахь шатны саналаар	14.7	4	12.4	4
ХОЛИМОГ	7.9	9	16.4	8
Үл хамаарах (хосолсон)	6.0	10	14.0	9
Холимог	30.8	1	33.6	1
ПРОПОРЦИАНАЛЬ	6.7	3	14.8	3
Үл шилжих нэг санал	1.9	1	3.8	1
Пропорцианаль төлөөлөл, жагсаалтаар	6.7	3	14.8	3
АЛЬ НЬ Ч БИШ				
Сонгуулиар бий болоогүй хуль тогтоох байгууллага	7.9	3	14.9	2
Бүгд	7.8	39	12.4	35

Тэмдэглэл: *Сонгуулийн тогтолцоог ангилсан байдлыг 6 дугаар хүснэгтээс үзнэ үү.*

Эх сурвалж: *Олон Улсын Парламентын холбоо, "Парламент дахь эмэгтэйчүүдийн тухай" http://www.ipu.org/*

Суудал хадгалах тухай

Дэлхийн хэмжээнд арав гаруй улс орон парламентын доод болон дээд танхимдаа эмэгтэйчүүдэд зориулан суудал хадгалах тухай Үндсэн хуулиндаа тусгажээ. Энэ аргыг ихэвчлэн нэг мандаттай тойрог бүхий сонгуулийн тогтолцоонд хэрэглэж байна. Гэвч Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын хувьд томилох, шууд бус ба шууд сонгуулиар ийнхүү хадгалсан суудлыг нөхсөний үр дүнд эмэгтэйчүүдийн оролцоонд гарсан өөрчлөлт харилцан адилгүй байна. Мөн зорилт ба түвшин хэрэгжүүлсэн хэлбэр нь ч өөр өөр байна. Орон нутаг, муж, үндэсний хууль тогтоох байгууллагад тодорхой тооны суудал хадгалах талаар үндсэн хуульд зааж өгөх нь хамгийн үр дүнтэй байна. Сонгууль зохион байгуулах байгууллага тухайн тойргийг тохиолдлоор сонгож, сонгууль тус бүрд өөрчилнө.

Суудлыг ардчилсан үйл явцаар нөхөх бөгөөд янз бүрийн улс төрийн намыг төлөөлсөн эсвэл бие даагч эмэгтэйчүүд сонгуулиар өөр хоорондоо өрсөлдөж сонгуулийн дүнг аль нэг удирдлага, нам, парламент биш сонгогчид тодорхойлно.

Афганистан, Бангладеш, Пакистан, Энэтхэг зэрэг Өмнөд Азийн хэд хэдэн улсад үндэсний болон орон нутгийн түвшинд суудал хадгалалтыг ашиглаж ирсэн арвин туршлага бий. Суудал хадгалах аргыг анх 1930-аад оноос эхлэн ашигласан бөгөөд хэдий бусад сонгуулийн тогтолцоонд ашиглаж болох ч нэг мандаттай тойрог бүхий сонгуулийн

тогтолцоотой улс орнуудын дунд сүүлийн үед илүү түгээмэл тархжээ. Эхэн үедээ эмэгтэйчүүдэд зориулан цөөн тооны суудал хадгалахаар тогтоож өгч байсан бол сүүлийн үед энэ тоо олширч байна.[41] Дээрээс шууд томилогдох, эсвэл нам, парламентын бусад гишүүний дэмжлэгээр шууд бус сонгуулиар сонгогдож хадгалсан суудлыг эзлэх ба олон нийтийн ардчилсан хууль ёсны дэмжлэгийг авч бүх нийтийн, өрсөлдөөнт сонгуулиар хадгалсан суудлыг эзлэх хоёрын хооронд ялгаа бий.

Өмнөд Азийн улс орнуудаас Бангладеш (300-аас 30), Пакистанд (357-оос 60) суудал хадгалдаг бөгөөд парламентын доод танхимд эзлэх гишүүдийн харьцаанд дүйцүүлэн хадгалагдсан суудлыг хуваарилдаг. Афганистан, Балба, Филиппин, Тайванд суудал хадгалалтыг мөн ашигладаг. Бангладеш, Пакистан, Энэтхэгийн тосгоны зөвлөлийн суудлын 30 хувийг эмэгтэйчүүдэд хуваарилдаг гэх мэтээр орон нутгийн түвшинд ч уг бодлого амжилттай хэрэгжиж байна.

Газар нутаг, хэл соёл, гарал үүсэл, шашны хувьд цөөнх иргэдийн төлөөллийг сонгохдоо суудал хадгалах аргыг мөн ашиглаж байна.[42] Энэ аргын үр дүн нь тухайн нийгмийн бүлгийн хэмжээ, газарзүйн хувьд хэр төвлөрөн суурьшдаг зэргээс хамаардаг. Үндэсний цөөнхөд зориулан суудал хадгалах квотыг хорь гаруй улсад ашиглаж байна. Жишээ нь: Пакистан, Фижи, Шинэ Зеландад эдгээр суудлыг тухайн бүлгээс томилсон, эсвэл шууд сонгосон төлөөлөл эзэлдэг. Сингапурын хувьд Евроази, Малай, Хинди гаралтай цөөнх төлөөллийн бүлгээр дамжуулан дуу хоолойгоо илэрхийлдэг. Мауритус улсад Креол, Лал, Хинди, Хятад гаралтай бүлгүүдэд 8 суудал хуваарилдаг. Энэтхэгийн муж бүрт зарим каст, овгийн нэр дэвшигчдэд зориулсан тодорхой тооны суудал байдаг.

Үндсэн хуульд заасан суудал хадгалах арга бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжиж буйг Афганистан, Бангладеш, Пакистан, Энэтхэгийн туршлагаас харж болно.

Афганистан

Холбогдох асуудлаар Афганистаны Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт 2004 онд оруулсан. (Шигтгээ 1-ийг харна уу). Дараа жил нь батлагдсан сонгуулийн тухай хуульд суудал хадгалах квотыг ашиглах талаар заасан. Үүний дагуу тус улсын парламентын доод танхимын 249 суудлаас (Волеси жирга) эмэгтэйчүүдэд хамгийн багадаа 68 суудал (27 хувь) ногдох талаар тусгасан. 2005 болон 2010 оны сонгуулиар Афганистан дээрх босгыг давсан. Охид, эмэгтэйчүүдэд хандах уламжлалт хандлага, Волеси жиргагийн сонгуулийн үеэр гардаг хүчирхийлэл, сүрдүүлгийг үл хайхран олон тооны эмэгтэй нэр дэвшигч сонгуульд оролцож, цөөнгүй нь амжилт гаргасан. 2010 оны байдлаар парламентын доод танхимын 27 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

ШИГТГЭЭ 1. Афганистанд суудал хадгалах аргыг ашиглаж буй байдал

Хямрал, зөрчлийн дараах шатанд байгаа улс орон эмэгтэйчүүдэд зориулан суудал хадгалах арга хэмжээ баталсан тухай, мөн энэ нь уламжлалт соёлын хэв маягт хэрхэн нөлөөлж болохыг Афганистаны жишээнээс харж болно. Афганистаны парламентын үйл ажиллагаа 1973 оноос хойш тасарсан бөгөөд Шинэ Ардчиллын үе хэмээгдэж байсан 1963-1973 оны үед ч хааны зарлигаар шийдвэр гарч байв. Харин Талибаны дэглэм нурж, ардчилал, хүний эрхийг дээдлэх чиглэлээр олон улсын шахалт нэмэгдэж, шинэ Үндсэн хууль баталсан нь улс төрийн шинэ институцыг хөгжүүлэх, эмэгтэйчүүдийг нийгмийн амьдралд татан оролцуулахад шийдвэрлэх нөлөө үзүүлэв.

Тус улсын шинэ Үндсэн хуулийг Үндсэн хуулийн төсөл боловсруулах хороо болон Үндсэн хуулийг хянан нягтлах хороо боловсруулж, 2003 оны 12 дугаар сард Лояа Жирга (Их Ассамблей) хэлэлцсэн байна. Эдгээр байгууллага бүрт эмэгтэйчүүд багтаж байсан бөгөөд Лояа Жиргагийн гишүүдийн 12 хувь, Үндсэн хуулийн төсөл боловсруулах 9 гишүүнтэй хорооны 2 нь эмэгтэй байв.

НҮБ тэргүүтэй олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажилд шинжээчид оролцуулж дэмжлэг үзүүлж байсны дотор эмэгтэйчүүдийн эрхийг хангах асуудал орж байв. Афганистаны эмэгтэйчүүдийн бүлгүүд, ялангуяа цөллөгт байсан эмэгтэйчүүд шинэ их хуралд суух эмэгтэйчүүдийн квотыг 25 хувьд хүргэх, Эмэгтэйчүүдийн эрхийн талаар хууль батлахыг идэвхийлэн уриалж байв.

2004 оны 1 дүгээр сард батлагдсан Афганистаны шинэ Үндсэн хуулинд тус улсын Үндэсний ассамблейн хоёр танхимын аль алинд хамаарах эмэгтэйчүүдийн квот баталсан. Үндсэн хуулийн 5 дугаар бүлгийн 83 дахь заалтад парламентын доод танхим Волеси Жиргагийн талаар тусгахдаа:

“*Волеси Жиргагийн гишүүд ард иргэдийн дунд зохион байгуулагдсан чөлөөт, бүх нийтийн, нууц, шууд сонгуулийн үндсэн дээр сонгогдоно. Тэдний бүрэн эрхийн хугацаа сонгууль болсноос таван жилийн дараах Саратан (сарын) 1-ний өдөр буюу шинэ Ассамблей үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөр дуусгавар болно. Волеси Жиргагийн гишүүдийн тоо муж бүрийн хүн амын тоотой пропорциональ байх бөгөөд хоёр зуун тавиас илүүгүй байна. Сонгуулийн тойрог болон холбогдох бусад асуудал Сонгуулийн хуулийн дагуу тодорхойлогдоно. Улсын нийт ард иргэдийн бүх нийтийн болон шударга төлөөллийг хангахуйц сонгуулийн системийг бий болгоход чиглэгдсэн арга хэмжээ сонгуулийн хуулинд тусгагдах бөгөөд аймаг, муж бүрээс хоёроос багагүй тооны эмэгтэй гишүүн сонгогдох ёстой*” гэж заажээ.

Үндсэн хуулинд парламентын нийт гишүүний тоог тодорхойлсон бөгөөд нийт 34 муж тус бүрээс дор хаяж хоёр эмэгтэй гишүүн Волеси Жиргад шууд сонгогдоно хэмээн заасан. Өөрөөр хэлбэл, 68 эмэгтэй парламентын доод танхимын гишүүн болох бөгөөд энэ нь нийт гишүүний 27,3 хувьтай тэнцэж буй ажээ. Хэдий тийм ч Үндсэн хуулиар сонгуулийн системийн төрөл болон эмэгтэйчүүдийн оролцоог хэрхэн баталгаажуулахыг тодорхойлоогүй ажээ. Үндсэн хуулийн дагуу парламентын дээд танхим буюу Мешрано

Жиргагийн гишүүдийн гуравны нэгийг, (тэдний тэн хагас нь эмэгтэйчүүд байх ёстой) Ерөнхийлөгч томилох эрхтэй. Орон нутгийн зөвлөлийн гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй суудлыг мөн эмэгтэйчүүдэд зориулан хадгалдаг байна.

2005 онд батлагдсан Сонгуулийн хууль болон Сонгуулийн хорооны шийдвэр дээрх нөхцөл, шаардлагыг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон. Афганистаны Волеси Жиргагийн сонгуульд нэг удаагийн үл шилжих саналын системийг ашиглахаар болсон бөгөөд чингэснээр олон мандаттай тойрогт ердийн олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдох боломжтой болжээ. 1993 он хүртэл Японд ашиглагдаж байсан уг системийн дагуу сонгогчид олон мандаттай тойрогт нэг нэр дэвшигчийн төлөө цорын ганц санал өгдөг. Хамгийн олон санал авсан нэр дэвшигч ялагчаар тодордог. Энэ хэлбэр нь зохион байгуулалт болон санал тооллогын үйл явцын хувьд ихээхэн хялбар бөгөөд сайтар бэхжсэн нам болон улс төрийн бусад бүлэглэл бүрэлдэн бий болоогүй нөхцөлд ч ашиглах боломжтой тул уг тогтолцоог сонгосон байна. Одоогийн суурингийн хилээр тогтоосон олон нэр дэвшигчтэй тойрог мөн давуу талтай. Учир нь хүн амын тодорхой мэдээлэл дутагдалтай, цаг хугацаа бага байсан тул нэг гишүүнтэй тойрог бий болгоход түвэгтэй байгаа аж. Түүнчлэн уг систем аливаа бие даагч намын дэмжлэггүйгээр өөрийгөө нэр дэвшүүлэх боломж олгодог. Энэ системийн бас нэг давуу тал нь тухайн орон нутгаас сонгогдсон гишүүд тойрогтоо үйлчилж ажиллах, нэр дэвшигч нам дотроо төдийгүй ард түмний дэмжлэгийг авч өрсөлдөх нөхцлийг бий болгодог.

Нэр дэвшигч төвтэй сонгуулийн тогтолцооны сөрөг тал нь намын дотоод зохион байгуулалтыг сулруулдагт оршдог бөгөөд чингэснээр шинээр бүрэлдэн бий болох хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангахад хүндрэл учирдаг. Энэ бол пропорциональ бус сонгуулийн тогтолцооны нэг үр дагавар юм. Учир нь нэр дэвшигч маш бага саналын зөрүүгээр сонгогдох боломжтой, саналын дүн дэх өчүүхэн бага өөрчлөлт сонгуулийн дүнг хаашаа ч эргүүлж мэдэхээр байдаг. Мөн нэг удаагийн үл шилжих саналын систем нь намууд тойрог бүрт хичнээн тооны хүн нэр дэвшүүлэхээ шийдэхдээ алсыг харах боломж олгодог. Афганистаны сонгогчид нэр дэвшигчдийн маш урт нэрсийн жагсаалттай танилцаж байсан, тухайлбал Кабулын тойргийн сонгогчдын саналын хуудсанд 600 гаруй нэр дэвшигч бичигдэж байв. Харин тэдэнд сонголт хийхэд нь дөхөм болохуйц намын аливаа тэмдэглэгээ огт байгаагүй аж. Энэ нь овог аймгаа дагасан нутгийн удирдагчдыг сонгоход илүү боломж олгон парламентад хамтран ажиллах хөшүүргийг сулруулдаг.

Нэг удаагийн үл шилжих саналын систем нь эмэгтэйчүүдийн төлөөллийг хангах тухай Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан. Намын нэрсийн жагсаалтад эмэгтэй нэр дэвшигчдийг тодорхой хувь заан оруулах замаар эмэгтэйчүүдийн төлөөллийг хангах боломжгүй болсон. Намуудын сайн дурын квот ч Үндсэн хуулийн 83 дахь заалтыг хэрэгжүүлэхэд нөлөөлж чадахгүй. Хөрш зэргэлдээ Пакистан, Бангладеш дэх мажоритар тогтолцоотой орон, түүнчлэн Энэтхэгийн орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүд, үндэстний цөөнхөд зориулан суудал хадгалах арга ашигладаг нь Афганистаны шийдвэр гаргагч нарт нөлөөлсөн байх талтай. Афганистаны Сонгуулийн хороо Үндсэн хуульд заасан нөхцөлийг хангах үүднээс муж бүрийн хүн амын тоонд тулгуурлан хадгалах суудлын тоог тогтоосон байна.

Хоёр суудалтай суурин бүрт 2 эмэгтэй нэр дэвшигчид суудал хадгалах боломжгүй. Сонгуулийн хороо Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэхийн тулд нэг мужид ногдох Волеси Жиргагийн суудлын тоог хүн амын нь тоотой дүйцүүлж гаргасан байна. Тухайлбал, Кабулд 33 депутатын суудал ногдсоноос 9 нь эмэгтэй гишүүдэд хуваарилагджээ. Энэ тогтолцоо нь суурин бүрт хамгийн олон санал авсан нэр дэвшигчид жендэрээс үл хамааран бүх суудлыг дүүртэл сонгогдохоор зохион байгуулагдсан. Хэрвээ сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо хуулиар тогтоосон тооны доод хязгаарт хүрээгүй бол муж бүрт хамгийн олон санал авсан эмэгтэй уг хадгалагдсан суудалд сонгогдож байв. Чингэснээр эмэгтэй нэр дэвшигчид эрэгтэй нэр дэвшигчдээс хамаагүй бага тооны санал авсан ч парламентад сонгогдож байсан нь уг арга шударга үр дүнд хүргэж байгаа эсэхэд эргэлзэхэд хүргэдэг байна.

2005 оны 9 дүгээр сард болсон хууль тогтоох байгууллага Волеси Жиргагийн анхны сонгуульд 2835 нэр дэвшигч оролцсоноос 344 буюу 12,1 хувь нь эмэгтэй байв. Сонгуулийн дүнд 249 депутатын 68 буюу 27,3 хувь нь эмэгтэйчүүд болж, тус улс Олон улсын Парламентын холбооноос гаргасан парламент дахь эмэгтэйчүүдийн квотын харьцуулсан судалгаагаар 24 дүгээр байранд жагссан. Энэ үйл явц нь Афганистаны эмэгтэйчүүд боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авах, чөлөөтэй нүүн шилжих зэрэг олон тооны хүний үндсэн эрхийг урт удаан хугацаанд эдэлж чадаагүй, түүнчлэн сонгуулийн кампанит ажлынхаа үеэр багагүй сүрдүүлэг, мөрдлөг, заналхийлэлтэй тулгарсан гэдгийг бодолцвол үнэхээр гайхалтай амжилт юм. 2010 оны 9 дүгээр сард болсон парламентын сонгуульд урьд өмнө байгаагүй олон эмэгтэй нэр дэвшиж өрсөлдсөн. Уг сонгуульд дор хаяж 406 эмэгтэй нэр дэвшигч оролцсон бол 2005 оны сонгуульд 382 эмэгтэй өрсөлдөж байжээ. Тэдний эсрэг чиглэсэн элдэв сүрдүүлэг, аюулыг даван туулж 69 эмэгтэй буюу хадгалсан суудлаас нэгээр илүү тооны эмэгтэй парламентын гишүүнээр сонгогдож, парламентын нийт суудлын 27,7 хувь буюу хуулиар тогтоосон доод хязгаар болох 27,3 хувиас илүү суудлыг эзлэх болсон байна.

Бангладеш

Бангладеш тусгаар тогтнолоо зарласны дараах 1972 оны Үндсэн хуулиндаа парламентын нийт 315 суудлаас 15-ыг (4.7 хувь) эмэгтэйчүүдэд зориулан хадгалахаар заасан. Энэ тоог 1978 онд тус улсын ерөнхийлөгчийн шийдвэрээр 2 дахин нэмсэн байна. Уг арга хэмжээ түр зуурынх байсан тул 1987 онд цуцлагдсан. Үүний улмаас 1988 оны сонгуулийн дүнгээр парламент дахь эмэгтэйчүүдийн жин 10.6-аас 1.3 хувь хүртэл буурчээ. 1990-2001 онд суудал хадгалах аргыг эргэн хэрэглэсэн. 2004 оны 5 дугаар сарын 16-нд Үндсэн хуулийн 65(3) дугаар заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, эмэгтэйчүүдэд хадгалсан суудлын тоог 45 (13 хувь) болгосон. Эдгээр нь шууд бус сонгуулиар нөхөгдөх суудал байв. Эмэгтэйчүүд хадгалагдсан суудлаас гадуурх суудлын төлөө өрсөлдөж болно. 2008 сонгуулийн дүнгээр 18 эмэгтэй шууд сонгогдож, парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл эргээд 19 хувь болсон байна.

Харамсалтай нь хадгалагдсан суудлыг хуваарилж буй байдал ихээхэн шүүмжлэл дагуулдаг.[43] Эрх баригч нам парламентад олонхийн байр сууриа бэхжүүлэх зорилгоор

ашигладаг байсны улмаас шууд бус сонгох үйл явц хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдөж чадахгүйд хүрсэн байв. Суудал хадгалах зорилтын сүүлд тогтоосон түвшин (13 хувь) ч нэлээд доогуур түвшин юм. Түүнчлэн намын удирдлагын зүгээс томилогдсон эмэгтэйчүүд олон нийтээр хүлээн зөвшөөрөгдөх байдал сул, сонгогчдын тулгуур дэмжлэггүй, нам дотроо баттай байр суурьгүй, туршлага багатай тул бие даан ажиллах чадавхиар дутмаг байдаг. Човдхуригийн үзэж буйгаар парламентын эмэгтэй гишүүд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр хангалтгүй ажиллаж байжээ.[44] Зураг 4-т үзүүлснээр Бангладешт улс төр дэх жендэрийн тэгш байдалд хандах уламжлалт соёлын хандлага хадгалагдан үлдэж, эмэгтэйчүүд нийтийн салбарт ажиллах хүсэл эрмэлзэлд саад тотгор болсон хэвээр байна. Бангладешд намын гишүүнчлэл дэх жендэрийн ялгаа 20 хувь байгааг Хүснэгт 4-т үзүүлсэн. Товчоор хэлбэл суудал хадгалалт байгаагүй, бусад арга хэмжээ аваагүй бол тус улсад эмэгтэй парламентчдын тоо үүнээс ч бага байх магадлал бий. Нөгөө талаас энэ бодлогыг хэрэгжүүлж байгаа байдлаас харахад суудал хадгалах нь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн чадавхи, мэдлийг нэмэгдүүлэхэд төдийлөн эерэг нөлөө үзүүлээгүй байна. Харин ч энэ нь голлох улс төрийн намын нэр дэвшигчээ тодруулах үйл явцад жендэрийн квот нэвтрүүлэх зэрэг илүү үр дүнтэй арга хэмжээ авахад саад болсон байж болзошгүй.

Пакистан

Пакистаны 1956, 1962, 1970, 1973 болон 1985 оны Үндсэн хуулиар орон нутаг ба Үндэсний ассамблейн аль алинд эмэгтэйчүүдэд зориулсан суудал хадгалсан заалт оруулсан байдаг. Гэхдээ хадгалах суудлын тоо бага, ихэвчлэн 5-10 хувийн хооронд хэлбэлзэж, парламентын гишүүдийн саналаар буюу шууд бус сонгуулиар сонгогдож байв.[45] Өнөөдрийн байдлаар үндэсний парламентын нийт 342 суудлаас 60 (17.5 хувь) нь эмэгтэйчүүдэд ногдож байна. Эдгээр суудлыг орон нутагт улс төрийн намуудын авсан сонгуулийн дүнд үндэслэн хувь тэнцүүлэн хуваарилдаг. 2008 оны сонгуулиар нийт 76 (22 хувь) эмэгтэй гишүүн парламентад сонгогдсон бол Засгийн газрын гишүүдийн дөнгөж 4 хувь нь эмэгтэй байна.

Орон нутгийн түвшинд П.Мушаррафын Засгийн газар Эрх мэдлийг сааруулах төлөвлөгөөг 2000 онд дэвшүүлсэн.[46] Үүнд дүүрэг, хот, зөвлөлийн түвшинд эмэгтэйчүүдийн квотыг 33 хувьд хүргэх явдал байв. Эдгээр нь журам, татвар, төсөв, урт болон богино хугацаат хөгжлийн төлөвлөгөө батлах эрх мэдэлтэй орон нутгийн хууль тогтоох байгууллагууд юм. Орон нутгийн засаг захиргаа бол ус, цэвэрлэгээ, зам, барилга, хүнс, хоол, эрүүл мэнд, суурь боловсрол зэрэг анхан шатны олон үйлчилгээ үзүүлдэг. Холбооны зөвлөл нь иргэний бүлэг, ядуурлыг бууруулах хоршоо байгуулж, ажиллуулахад мөн дэмжлэг үзүүлдэг. Энэ бүх түвшинд нийт 40,000 орчим орон тоог эмэгтэйчүүдэд хуваарилж, орон нутгийн засаг захиргааны зорилт, хийх ажлын дарааллыг шинээр харах боломж өгч байна. Сонгуулийн шинэчилсэн тогтолцооны дагуу 2002 онд сонгогдсон эмэгтэйчүүдийн дунд бичиг үсэгт тайлагдаагүй, туршлагагүй, нийгмийн эмзэг бүлэгт багтах иргэд олон байсан. Мөн дийлэнх нь сонгуульд өмнө нь оролцож байгаагүй хүмүүс байсан бөгөөд улс төрд шинэ үеийг авчирсан байна.

Энэтхэг

Энэтхэгийн Үндсэн хуулиар тосгоны сонгуульд жендэрийн квот тогтоож өгсөн. Үндсэн хуулийн 1992 онд батлагдсан 73, 74 дүгээр нэмэлт өөрчлөлтийн дагуу орон нутгийн түвшинд сонгууль явуулахаар зааж, эдгээр байгууллагад зардлын болон хяналтын

чиг үүргийг шилжүүлэн, мөн эмэгтэйчүүдэд нийт суудлын гуравны нэгийг олгохоор заасан. Үүнээс өмнө Энэтхэгийн муж болон үндэсний хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх жин 3-9 хувийн хооронд хэлбэлзэж байсан бол одоо гуравны нэгээс давжээ. Эмэгтэйчүүдэд хадгалагдсан суудлыг сугалаагаар сонгож, сонгууль бүрт өөрчилдөг. Ингэснээр суудал бүр хадгалагдах ижил боломжтой болж, шударга байдал хангагдан, аль нэг тойрогт эрэгтэйчүүд сонгогдох боломжгүй болохоос сэргийлдэг. Түүнчлэн зарим каст, овогт зориулан суудал хадгалдаг.

ШИГТГЭЭ 2. Энэтхэгт суудал хадгалдаг туршлага

Энэтхэгийн Үндсэн хуулийн 74 дүгээр нэмэлт заалт ёсоор орон нутгийн удирдах байгууллага болон мужийн Панчаят (орон нутгийн чанартай гол асуудлыг хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргадаг зөвлөл)-ын 33 хувийг шууд сонгуулиар сонгогдсон эмэгтэйчүүд бүрдүүлэх ёстой аж. Тосгоны удирдах зөвлөл буюу прадханы суудлын гуравны нэгийг мөн эмэгтэйчүүдэд зориулан хадгалдаг. Энэ нь Энэтхэгт улс төрийн маргаан дагуулдаг шийдвэр юм. Ийм зохицуулалтыг анх 1993 онд ядууралтай тэмцэх зорилгоор нутгийн засаглал, тосгоны зөвлөлийг сэргээн идэвхжүүлэх арга хэмжээний хүрээнд нэвтрүүлжээ. Гэвч сонгуулийн хуулийн зохицуулалтаараа тус улсын мужууд өөр хоорондоо ялгаатай. Зарим муж, тухайлбал, Андхра-Прадеш, Керала, Махараштра, Трипура-д панчаят болон орон нутгийн захиргаанд эмэгтэйчүүдийн квотыг 50 хувь хүртэл өсгөсөн бол зарим мужид, тухайлбал Ассам, Бихар, Чатигарш, Химачал-Прадеш, Мадья-Прадеш, Манипур, Раджастхан, Утраканд, Баруун Бенгал-д зөвхөн Панчаят дахь эмэгтэйчүүдийн квотыг нэмэгдүүлжээ.

Үүний дүнд зөвлөлд эмэгтэй гишүүн сонгогдох нь харьцангуй түгээмэл болсон. Тухайлбал, Делид эмэгтэй гишүүний тоо эрэгтэй гишүүдийнхээс олон болжээ. Делигийн мужийн зөвлөлийн 272 гишүүний 138 буюу 50 хувийг эмэгтэйчүүдэд зориулан хадгалахаас гадна 6 эмэгтэй тойрогт ялалт байгуулснаар нийт 144 эмэгтэй сонгогдсон байна. Гурван мужийн зөвлөлд эмэгтэйчүүд олонхи болжээ. Дорнод Делигийн зөвлөлийн 64 суудлын 35-ыг, Умард зөвлөлийн 104 суудлын 53-ыг, Өмнөдийн 104 суудлын 56-г эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Түүнчлэн зөвлөл бүрийг эхний жил нь эмэгтэй хүн даргалах учиртай бөгөөд эмэгтэй хүн арав гаруй жилийн турш удирдаж байна.

Энэтхэгийн суудал хадгалах квотын туршлагыг өргөн хүрээнд сонирхон судалж ирсэн. Суудал хадгалах аргыг санамсаргүй буюу сугалаагаар хэрэгжүүлдэг арга нь энэ бодлогын үр дүнг хагас туршилтын аргаар судлах боломж олгож байна. Саяхан хийгдсэн судалгаа тус улсын бодлогын тэргүүлэх чиглэлүүдэд өөрчлөлт орж, эмэгтэйчүүдийн чадварыг үнэлэх үнэлэмж нэмэгдэж, эмэгтэйчүүд сонгогдох боломж өсч, залуу охидын сурч боловсрох хүсэл эрмэлзэл нэмэгдсэнийг харуулжээ. Иймээс бодлогын үр дүнд хүрэхэд жендэр чухал нөлөөтэй гэдгийг тус судалгаа харуулж байгаа юм. Тодруулбал, эмэгтэй хүнээр удирдуулсан мужуудад цэвэр усны хангамж, нийтэд зориулсан дэд бүтцийн асуудалд илүү анхаарал хандуулж байсан бол эрэгтэй хүнээр удирдуулсан мужид ажлын байрны асуудалд хөрөнгө зарах хандлага илүү байжээ. Бусад зарим судалгаанд жендэрийн асуудлыг кастын системтэй холбон авч үзсэн байна. Хуваарилагдсан суудалд доод кастаас сонгогдсон эмэгтэй гишүүн эрүүл мэнд,

сургуулийн өмнөх боловсролд илүүтэй хөрөнгө оруулж, өв залгамжлал зэрэг “эмэгтэйчүүдэд ээлтэй” хуулинд ач холбогдол өгч, газрын шинэчлэл зэрэг баялгийг дахин хуваарилах асуудалд анхаарал хандуулдаг байна. Харин өндөр кастаас гаралтай эмэгтэй хууль тогтоогчид “эмэгтэйчүүдэд ээлтэй” хуулинд ач холбогдол өгөхгүйн дээр газрын шинэчлэлийн асуудлыг эсэргүүцэж, дээд боловсролд хөрөнгө оруулан, нийгмийн халамжийг бууруулахыг илүүд үздэг байна.

Суудал хуваарилах бодлогыг үндэсний парламентын доод танхим (Лок Сабха)-д нэвтрүүлэх оролдлого удаа дараа хийгдэж буй ч амжилт олоогүй байна. Парламентын 545 гишүүний 60 (11 хувь) нь эмэгтэй гишүүнээс бүрдэж буй Энэтхэгийн парламентын доод танхим уг үзүүлэлтээрээ дэлхийд 105 дугаар байранд орж байна. Үндсэн хуулийн 108 дугаар нэмэлт буюу Эмэгтэйчүүдэд суудал хадгалах тухай хуулийн төсөлд Лок Сабха болон мужуудын хууль тогтоох байгууллагуудад эзлэх эмэгтэйчүүдийн тоог 33 хувьд хүргэхийг санал болгож буй. Уг хууль 2010 оны 3 дугаар сарын 9-нд парламентын дээд танхим (Ража Сабха)-аар дэмжигдсэн хэдий ч доод танхимын дэмжлэгийг хараахан аваагүй байна.

Эндээс Үндсэн хуулийг шинэчлэх замаар суудал хадгалалтыг баталсан байдал нь бидний авч үзсэн улс бүр дээр өөр байна гэсэн дүгнэлт хийж болно. Гэвч гол асуудал бол хэрхэн хэрэгжүүлж байгаад оршиж байна. Жишээ нь, эмэгтэйчүүд шууд, шууд бусаар сонгогдож байгаа эсэх, суудал хадгалах хувь, улс тус бүрийн засаглалын онцлог зэргийг үүнд оруулж болно. Бангладешд суудал хадгалалтыг ашиглан буй байдал нь таагүй уур амьсгал үүсгэж байгаа бол Энэтхэгийн орон нутгийн засаглалд үр дүн эерэг байна.

Эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан хуулиар квот тогтоох

Эмэгтэй нэр дэвшигчдийн хуулиар тогтоосон квотыг хөгжиж буй олон оронд хэрэглэгддэг. Сонгуулийн тухай хууль, зарим тохиолдолд Үндсэн хуулинд тусгах замаар нэр дэвшигчдийнхээ тодорхой хувийг эмэгтэй хүн байлгахыг бүх намаас шаарддаг. Жендэрийн квотыг шүүх засаглал, нийтийн албанд жендэрийн тэгш байдал тогтоох үүднээс ашиглаж болно. Энэ бодлого 1990-ээд оны үед өргөнөөр тархаж эхэлсэн бөгөөд сүүлийн 10 жилд олон улс оронд ийм санал дэвшүүлж, нэвтрүүлээд байна. Бүс нутгийн хүрээнд парламентын доод танхимын суудалд өрсөлдөх нэр дэвшигчдийн дунд жендэрийн тэгш байдлыг хангах үүднээс БНСУ, Зүүн Тимор, Монгол, Хятадад квот ашиглаж байна.

Хуулиар тогтоосон квот нь ерөнхийдөө сонгуульд оролцох нэр дэвшигчдийн 25-50 хувь эмэгтэй байхыг шаарддаг. Ихэнх тохиолдолд энэ арга хэмжээ нь жендэрийн нэг талыг баримтлалгүй, төлөөлөл нь хангалтгүй байгаа аль нэг хүйсийн оролцоог дэмждэг. Гэхдээ уг квотыг хэр хатуу илэрхийлсэн бэ гэдгээрээ улс орнууд ялгаатай байдаг. Заримдаа боломж бүрдүүлэх хэмээн бүрхэг тодорхойлж байхад бусад тохиолдолд эмэгтэй нэр дэвшигчдийг шалгаруулж тодруулах нарийвчлалын журам баталсан байдаг. Намын сайн дурын квоттой (дор дурдана) адилаар сонгуулийн тогтолцооноос хамаарч хэрэгжилт нь олон янз байдаг. Ихэвчлэн намын жагсаалт болон нэг мандаттай тойргийн багцаар хэрэглэнэ. Хуулиар тогтоосон квот тул үл биелүүлсэн тохиолдолд торгууль, шийтгэл хүлээлгэж, Сонгуулийн ерөнхий хороо зэрэг байгууллага хяналт тавихаар заасан.

ХҮСНЭГТ 8 Парламентын доод танхимд нэр дэвшигчдэд олгосон квотын нөлөө (Ази, Номхон далайн орнууд)

Улс орнууд	Төрөл	Сонгуулийн тогтолцоо	Сүүлийн хувилбар	Зорилт %	Зиндаа тогтоох шалгуурууд	Мөрдөөгүй тохиолдолд шийтгэл хүлээлгэдэг эсэх	2000 он хүртэлх эзэлж байсан эмэгтэйчүүдийн хувь (одоогийн хуульгарахаас өмнө)	2010 онд эзэлж байсан эмэгтэйчүүдийн хувь (хуульгарсны дараа)	Өөрчлөлтийн хувь
Афганистан	Суудал хуваарилдаг	Үл шилжих санал	2004	27			--	28	+1
Бангладеш	Суудал хуваарилдаг	Нэг мандаттай мажоритар	2004	13			9	19	+10
Хятад	Хуулийн квот	Шууд бус	2007	22			22	21	-1
Индонези	Хуулийн квот	Хувь тэнцүүлсэн	2009	33	Тийм	Үгүй	8	18	+10
Монгол	Хуулийн квот	Холимог	2012	20	Үгүй	Үгүй	4	-	
Балба	Суудал хуваарилдаг	Холимог	2007	33			6	33	+27
Пакистан	Суудал хуваарилдаг	Холимог	2004	17.5			17	22	+5
Филиппин	Суудал хуваарилдаг	Холимог					11	22	+11
БНСУ	Хуулийн квот	Холимог	2004	30-50	Үгүй	Үгүй	4	15	+9
Тайвань	Суудал хуваарилдаг	Холимог	2005	10-15				22	
Зүүн Тимор	Хуулийн квот	Хувь тэнцүүлсэн	2007	25	Тийм	Тийм	-	29	
АНД-н бүх орон							**8**	**13**	**+5**

Тэмдэглэл: *АНД-н бусад орон парламентад нэр дэвшигчдэд зориулсан жендэрийн квотын хуулийг хэрэглэдэггүй. Эх сурвалж: www.quotaproject.org*

Бүс нутгийн сонгуульт албан тушаал дахь жендэрийн тэгш байдалд суудал хадгалалт, хуулиар тогтоосон квотын үзүүлэх нөлөөг Хүснэгт 8-д үзүүлэв. Үүнд бүс нутгийн 11 орныг дээрх үзүүлэлтийн аль нэгээр харьцуулав. Энэ чиглэлийн үйл ажиллагаа саяхнаас хэрэгжиж эхэлсэн тул урт хугацаат чиг хандлагыг тодорхойлоход мэдээлэл хангалтгүй байна. Бид хүснэгтэд байгаа мэдээлэлд үндэслэн энэ төрлийн бодлогыг хамгийн сүүлийн хувилбараар хэрэгжүүлэх болсноос өмнөх болон дараах байдлыг

7 улсын парламентын доод танхим дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг 2000 болон 2010 оны байдлаар харьцуулах боломжтой байв. Суудал хадгалдаг болон хуулиар тогтоосон квот ашигладаг 7 улсын үзүүлэлт 2000 оноос 2010 оны хооронд дунджаар 10.1 хувиар өссөн байв. Бусад бодлогын арга хэмжээ, соёлын хандлага жендэрийн тэгш байдал бас нөлөөлдөг тул дээрх өсөлтийг зөвхөн суудал хадгалалт, албан ёсны квоттой холбон тайлбарлаж болохгүй. Албан ёсны квот нэврүүлээгүй бүс нутгийн бусад оронд уг үзүүлэлт өссөн ч 5 хувиар буюу бага хувиар өссөн байна. Эндээс энэ төрлийн арга хэмжээний цэвэр үр нөлөөг 10 жилд дунджаар 5 хувь гэж тооцож болох юм. Албан ёсны квотын зохицуулалт, хэрэгжүүлэлт өөр байгаа тул энэ арга хэмжээний үр дагаврыг тоогоор илэрхийлэхэд хэлбэлзэл ихтэй байна. Пакистан зэрэг улсад үр нөлөө дунд зэрэг байхад Балбад огцом өөрчлөлт гарчээ. *Энэ ялгаа нь суудал хадгалах болон албан ёсны квот тогтоох байдал, зорилтот түвшин, байршуулал, дарааллыг заадаг эсэх, биелүүлээгүй тохиолдолд торгууль шийтгэлийг авч хэрэгжүүлж байгаа эсэх зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой*.[47]

Индонезид зорилтот түвшин нийт намын нэр дэвшигчдийн гуравны нэгтэй тэнцүү байна. Сонгуулийн хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтөд (2003/12, 65(1) хэсэгт) “сонгуульд оролцох намууд орон нутаг, муж, үндэсний парламентад нэр дэвшүүлэхдээ сонгуулийн тойрог бүрт эмэгтэйчүүд 30 хувийн төлөөлөлтэй байхаар тооцно” гэжээ. 2004 оны сонгуульд намууд энэ шаардлагыг биелүүлж чадаагүй. Эмэгтэй нэр дэвшигчид намын жагсаалтын доогуур бичигдэж байсан бөгөөд дээрх хуульд хэрэгжүүлэх механизмыг заагаагүй.[48] 2004 оны сонгуульд 3 хувийн босгыг давсан 7 намаас дөнгөж 3 нь (Үндэсний сэргэн мандалтын нам, Үндэсний мандатын нам, Хөгжил дэвшил, шударга ёс нам) нэр дэвшигчдийнхээ 30 хувийг эмэгтэйчүүдээс бүрдүүлжээ. Мөн ил тод байдлыг дээшлүүлэхээр 2008 онд сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан боловч биелүүлээгүй нөхцөлд тооцох хариуцлагыг тодорхой заагаагүй. 1999 онд Индонезийн доод танхим дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 8 хувь байсан бол 2004 онд 11.3 хувь, 2009 онд 16.8 хувь болжээ. Энэ хугацаанд сонгуульт албан тушаал дахь эмэгтэйчүүдийн тоо хоёр дахин нэмэгдсэн боловч зорилтот түвшин 30 хувьд хүрэхэд нэлээд хол байна.[49]

Квотын үр нөлөө ялгаатай байгаа талаарх хоёр дахь тайлбар сонгуулийн тогтолцооны орчин нөхцөлтэй холбоотой. Олон мандаттай тойрог бүхий пропорциональ тогтолцоотой улс орнуудын хувьд квот хамгийн их нөлөөтэй.[50] Шведэд олон мандаттай тойрогт намын жагсаалтаар нэр дэвшигчдийг сонгодог. Харин нэг мандаттай тойрогт суудал хадгалах квот ашиглах нь хүндрэлтэй байдаг. Квот олон намын тогтолцоотой, томоохон нам нь бусад жижиг намын шинэчлэлийн санаачлагыг хүлээж авдаг улсад түүнчлэн нам, үндэсний журмыг сахиулах чадвар бүхий удирдлагатай зүүний намын хүрээнд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд илүү үр дүнтэй байх тал бий.

Үүнээс гадна улс төрийн соёл нь бүлгийн төлөөлөл, жендэрийн ялгааг хүлээн зөвшөөрдөг улс төрийн квот илүү амжилттай хэрэгждэг. Харин хувь хүний төлөөлөл хүйсийн тэгш байдлыг дэмждэг нийгэмд бага нөлөөтэй.[51] Квотыг Үндсэн хуулинд заасан эрх тэгш байдлын тухай зарчимд үл нийцсэн хэмээн үздэг Их Британи, Испани, Италийн жишгээс үүнийг харж болно. Гэвч энэ бол

олон улсын гэрээ конвенцид үл нийцэх зүйл юм. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн 4 дүгээр зүйлд "*Эрэгтэй, эмэгтэйчүүдийн де факто тэгш байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн түр тусгай арга хэмжээг алагчлалд үл тооцно*" гэсэн байдаг.

Квот ялгаатай үр дүн авчирч байгаад нөлөөлж буй гурав дахь хүчин зүйл нь улс төрийн хүсэл эрмэлзэл юм. Намын удирдлага, ажилтан, идэвхтэн, гишүүн зэрэг нэр дэвшигчийг сонгоход оролцдог хүмүүс квотыг ашиглахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Уг арга хэмжээ хэр үр дүнтэй байх нь эдгээр хүмүүсийн эмэгтэй нэр дэвшигчийг элсүүлж сонгох хүсэл эрмэлзлэлээс ихээхэн шалтгаална. Ийнхүү элсүүлэн сонгох асуудал хариуцсан ажилтнуудын дийлэнх нь эрэгтэй байдаг. Намын гишүүнчлэл дэх жендэрийн тэнцвэрт бус байдал удирдах түвшинд дөхөх тусмаа ихэсч байгааг Хүснэгт 3-аас харж болно. Олон тохиолдолд элсүүлж сонгох асуудал хариуцсан ажилтнууд квотын шаардлагыг биелүүлээгүй байхад дуугүй өнгөрөх маягаар далд эсэргүүцэх, эсвэл квотын үр нөлөөг нь бууруулах идэвхтэй арга хэмжээ авах зэргээр саад учруулдаг. Энэ нь даамжирч сонгуулийн томоохон луйвар, булхай болох магадлалтай. Гэхдээ нам доторх болон намаас гаднах эмэгтэйчүүдийн байгууллага, үндэсний болон олон улсын шүүх, энгийн иргэд зэрэг бусад олон тал квотын хэрэгжилтэд шууд ба шууд бусаар нөлөөлж, квотын шаардлагыг намууд биелүүлж байгаа эсэхийг хянаж байдаг.

Квотыг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх зорилготой кампанит ажил эдгээр бүх оролцогчдод эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Зарим улсад ард түмний үүсгэлтэй эмэгтэйчүүдийн хөдөлгөөн квотыг улс төрийн чухал зорилт болгон хувиргадаг. Нөгөө талаас эмэгтэйчүүдийн саналыг авах гэсэн улс төрийн элитийн стратегийн тооцооноос үүдэн квотыг дэмждэг.[52] Энэ нь удаан хугацаанд гүйцэтгэсэн сөрөг хүчний үүрэг ролиос салах гэсэн эсвэл нэр хүндээ хурдтай алдаж буй улс төрийн намын хувьд чухал ач холбогдолтой болдог. 3 дахь төрлийн тоглогч бол олон улсын байгууллага, үндэстэн дамжсан төрийн бус байгууллагууд юм. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд НҮБ, Социнтерн, Европын зөвлөл, Европын холбоо, Британийн Хамтын нөхөрлөл, Африкийн холбоо, Өмнөд Африкийн хөгжлийн нийгэмлэг, Америкийн улсуудын байгууллага зэрэг олон улсын байгууллага Бээжингийн тунхаглалын дагуу улс төрийн тавцан дахь эмэгтэйчүүдийн оролцооны түвшинг 30 хувьд хүргэхийг уриалж байв.[53]

Одоогийн болон үүсч буй улс төрийн үнэлэмжтэй хослуулсан уриалга, санаачлага ихээхэн амжилтад хүрдэг. Жишээ нь зүүнийн чиг баримжаатай намуудын ерөнхий зорилго болох нийгмийн тэгш байдалтай квот нийцдэг тул энэ тал дээр илүү нээлттэй өөриймсөг ханддаг ерөнхий шинж ажиглагддаг.[54] Бусад улсын хувьд жендэрийн квотыг хэл соёл, шашин шүтлэг, угсаа гарал, бусад хүчин зүйлээс шалтгаалсан нийгмийн бүлгүүдэд чиглэсэн арга хэмжээний нэгэн хэсэг гэж тооцогддог. Жишээ нь Энэтхэгт доод кастынханд зориулан суудал хадгалсны дараагаар орон нутгийн түвшинд эмэгтэйчүүдийн квот хэрэгжсэн.[55] Төгсгөлд нь тэмдэглэхэд мөргөлдөөнөөс дөнгөж ангижирсан нийгмийн жишээгээр ардчилсан шилжилтийн явцад олон төрлийн квот бий болдог нь шинэ улс төрийн тогтолцоо хууль ёсны байдлаа бэхжүүлэхэд квот эерэгээр нөлөөлдөг гэж үздэгтэй холбоотой.

ШИГТГЭЭ 3. Киргиз улс дахь хуулиар тогтоосон квот

Киргиз бол БНХАУ-тай хил залгаа оршдог Төв Азийн улс бөгөөд 1991 онд ЗХУ задран унаснаар тусгаар тогтнолоо олж авсан. 2005 оны Киргиз Улсын парламентын сонгуульд нэг ч эмэгтэй гишүүн сонгогдоогүй. Ингэснээр Засгийн газар дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл суларч зөвхөн нэг эмэгтэй сайдтай, нэг ч эмэгтэй дэд сайдгүй, удирдах дээд албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь огцом буурсан байна.

Иргэний нийгмийн байгууллагуудын нөлөөллийн ажлын үр дүнд 2007 оны 10 сард Киргиз Улсын Үндсэн хуулийн 13 дугаар зүйл болох эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш эрх, боломж олгосон заалт шинээр батлагдсан. Сонгуулийн хуулийг шинэчлэн батлахдаа уг заалтыг баримтлан парламентын сонгуульд оролцож буй улс төрийн намуудын сонгуулийн нэрсийн жагсаалтанд жендэрийн квот тогтоосон. Киргиз Улсын парламент буюу Дээд Зөвлөл (Жогорку Кенеш)-д 120 гишүүн пропорциональ системээр 5 жилийн хугацаатай сонгогддог. Сонгуулийн тухай хууль нь нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувь байна (72 дугаар зүйл), мөн эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийн хоорондын зай 3-аас илүүгүй байхаар заасан. Энэхүү жендэрийн квотыг тусгаагүй жагсаалтыг Сонгуулийн хороо буцаана. Уг арга хэмжээний үр нөлөө тэр даруй гарсан. 2007 оны 12 дугаар сарын сонгуулийн үр дүнд Киргиз Улсын парламентын гишүүдийн 23 (25,6 хувь) нь эмэгтэй гишүүд болов. Энэ үзүүлэлтээр Киргиз Улс Төв Азийн улсууд дотроо хамгийн сайн эмэгтэйчүүдийн төлөөллөөр тэргүүлэгч улс болсон байна.

2010 оны 4 дүгээр сард улам бүр доройтож буй амьдралын түвшин, хээл хахуульд ундууцсан ард иргэдийн бослогоор Ерөнхийлөгч Курманбек Бакиевыг албан тушаалаас нь авч хаясан. Сөрөг хүчин давамгайлсан түр Засгийн газар Роза Отунбаева хэмээх эмэгтэйг түүний оронд улсын тэргүүнээр зарласан. Шинэ албан тушаал хүлээж авснаас хойш хэдэн сарын хугацаанд Отунбаева шинэ Үндсэн хууль батлахаар ард түмний санал асуулга зохион байгуулж, санал асуулгад оролцогчдын 90 хувь нь Ерөнхийлөгчийн эрхийг хязгаарлах, хуучин ЗХУ-ын Төв Ази дахь анхны парламентын ардчилал руу шилжихэд чиглэгдсэн шинэ Үндсэн хуулийг дэмжсэн. Ингээд 2010 оны 6 дугаар сард шинэ Үндсэн хууль батлагдаж, Киргиз Улс парламентын Бүгд найрамдах улс болсон. Отунбаева албан ёсоор Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгчийн тангараг өргөсөн ба тэрээр коммунист дэглэм нуран унасны дараах тус бүс нутгийн анхны эмэгтэй удирдагч болсон. 2011 оны 10 дугаар сард Ерөнхийлөгчийн сонгууль явуулах тов зарлагдсан. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах зэрэг 30 орчим олон улсын конвенц, олон тооны хууль баталснаар Киргиз Улсад жендэрийн тэгш байдлыг хангах суурь сайн тавигдаж байна.

ШИГТГЭЭ 4. Номхон далайн Францын газар нутгууд дахь хуулиар тогтоосон квотын хэмжээ

Номхон далай дахь Францын газар нутгууд болох Каледониа, Францын Полинез болон Виллис ба Футунад хууль тогтоох дээд байгууллага болох Ассамблейг пропорциональ төлөөллийн системээр сонгогддог. Эдгээр газар нутаг нь 2000 оны Францын тэгш эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх ёстой ба уг хуулийн дагуу улс төрийн намуудын нэрсийн жагсаалтын 50 хувь нь эмэгтэй байх ёстой. Үүнийг "цахилгаан товчны жагсаалт" гэж нэрлэх нь бий (учир нь жагсаалтын эхнээс төгсгөл хүртэл эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийг сөөлжилж бичдэг). Тэгш эрхийн тухай хууль болон пропорциональ системийн үр дүнд Францын Номхон далайн эзэмшил газрууд, Номхон далайн бусад арлаас ихээхэн ялгардаг. Тухайлбал, Шинэ Каледониагийн хууль тогтоох байгууллагын нийт гишүүдийн 52,6 хувь, Францын Полинезийн 42,1 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг байна.

Хэдийгээр дээрх арга хэмжээ үр нөлөөтэй боловч Францын Валлис ба Футүнад арай өөр дүр зураг ажиглагддаг. Энэ нь улс төрийн намуудын тоо олон, дүүргийн мандатын тоо цөөнтэй холбоотой. Тэгш эрхийн тухай хуулийн хүрээнд эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийн нэрсийг сонгуулийн жагсаалтад сөөлжүүлэн оруулсан боловч, 2002 оны сонгуульд оролцсон 32 намын жагсаалтын бүгдийнх нь эхэнд эрэгтэй нэр дэвшигч бичигдсэн байна. Зөвхөн нэг нам хууль тогтоох байгууллагад нэгээс дээш тооны гишүүнтэй байх эрхтэй болсон тул зөвхөн нэг л эмэгтэй хууль тогтоох дээд байгууллагад сонгогдсон. Харин нэг эрэгтэй гишүүн ажлаасаа огцорч, бас нэг гишүүн нас барсны улмаас хоёр эмэгтэй гишүүн Хуралд оролцох эрхтэй болсон. 2007 оны сонгуульд 20 нам парламентад суудал авсан боловч зөвхөн 3 нам сонгуулийн жагсаалтаа эмэгтэй нэр дэвшигчээр эхэлжээ. Улмаар 2 эмэгтэй нэр дэвшигч сонгогдсон. Валлис ба Футунагийн жишээ нь тухайн улсын сонгуулийн систем, улс төрийн намын тогтолцоо ба квот хэрхэн уялдаа холбоотой байдгийг харуулдаг.

Хуулиар тогтоосон квотын жинтэй нөлөөг Киргизийн жишээнээс харж болно. Тус улс эмэгтэйчүүдийн оролцоог 30 хувь гэж заахаас гадна намын жагсаалтад эрэгтэй, эмэгтэйчүүдийн хооронд 3-аас илүү зай гаргахгүй байх гэсэн шаардлага бүхий хуулийг 2007 онд баталсан. Сонгуулийн пропорциональ тогтолцоотой хослон хэрэгжсэн уг бодлого эмэгтэйчүүдийн төлөөллийг 2007 оны сонгуулийн дараа маш богино хугацаанд 0-оос 25 хувь хүртэл өсгөсөн юм (Шигтгээ 3-ыг харна уу).

Эмэгтэйчүүдийн төлөөллөөр сүүл мушгиж байдаг Номхон далайн бүс нутагт квотыг сонгуулийн пропорциональ тогтолцоотой хослуулсны дүнд Францын 2 газар нутагт орон нутгийн ассамблейн сонгуульд эмэгтэйчүүд амжилттай оролцох болов (Шигтгээ 4-ийг харна уу).

Эдгээрийг Хүснэгт 8 дахь мэдээлэлтэй нэгтгэн үзвэл хуулиар тогтоосон квот нь улс төрийн албан тушаалд ажиллах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үр нөлөөтэй арга хэмжээ гэдэг нь харагдаж байна. Ялангуяа албан ёсны квотын шаардлагыг нарийвчлан боловсруулж, пропорциональ тогтолцоотой хослуулж, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулснаар илүү үр дүнд хүрч байна. Жишээ баримтаас харахад дараах тохиолдолд хуулиар тогтоосон квот илүү амжилттай хэрэгжсэн байна. Үүнд:

(1) Улс төрийн намуудаас харьцангуй олон тооны эмэгтэй хүний нэрийг дэвшүүлэхийг шаардсан хууль эрх зүйн зохицуулалт;

(2) Намын жагсаалтад эмэгтэйчүүдийн нэрийг байршуулах асуудлыг сөөлжлүүлж зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалт (Үүнийг давхар квот тогтоох гэж нэрлэх нь бий);

(3) Хуулийн заалтыг биелүүлээгүй тохиолдолд мөнгөн торгууль хүлээлгэх, намын жагсаалтыг буцаах зэрэг торгууль шийтгэл ногдуулах, эсрэгээрээ эмэгтэйчүүдийн нэрийг ахиу дэвшүүлж байгаа улс төрийн намуудад эерэг хөшүүрэг олгох хууль эрх зүйн зохицуулалт,

(4) Шаардлагатай үед хуулийн болон улс төрийн арга хэмжээ авах замаар Сонгуулийн ерөнхий хороо, шүүх, ТББ, эмэгтэйчүүдийн байгууллага зэрэг бие даасан байгууллагаар дамжуулан хэрэгжилтэд өндөр хяналт тавьж ажиллах зэрэг болно.

VII. НЭР ДЭВШИГЧИЙГ СОНГОХ НАМЫН ДОТООД ДҮРЭМ, ҮЙЛ ЯВЦ

Суудал хадгалах болон хуулиар тогтоосон квот нь улс төрийн тавцанд жендэрийн тэгш байдлыг хангах зорилгоор төрийн зүгээс авч хэрэгжүүлэх бодлогын хэлбэр юм. Харин намын сайн дурын квот нь сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийнхээ тодорхой хэсгийг эмэгтэйчүүдээс бүрдүүлнэ гэсэн улс төрийн намын бие даасан шийдвэр юм. Үүнийг намын дүрэм, журамд тусгах замаар хэрэгжүүлдэг. Энэ төрлийн арга хэмжээг Баруун Европт социалист, социал демократ намууд 1970-аад онд анх хэрэгжүүлсэн. 1980, 1990-ээд онуудад дэлхийн өнцөг булан бүрт олон төрлийн нам квотыг ашиглаж эхэлснээр өнөөдөр хамгийн өргөн тархсан квотын хэлбэр болоод байна. Австрали, БНСУ, Индонези, Филиппин зэрэг Ази, Номхон далайн бүс нутгийн хэд хэдэн улс орны зарим нам нэр дэвшигчийг сонгох явцдаа жендэрийн квот ашиглаж байна.

Намууд ихэвчлэн 25-50 хувийн квот тогтоодог. Уг квотыг янз бүрийн байдлаар илэрхийлдэг. Аргентин, Испани, Өмнөд Африкт эмэгтэйчүүдийг квот ашиглан дэмжих учиртай бүлэг гэж үздэг бол Итали, Скандиновын орнуудад жендэрийн талаар төвийг сахисан бодлого хэрэгжүүлдэг. Намын квот пропорциональ, холимог сонгуулийн тогтолцоон дахь намын жагсаалтад нөлөөлдөг бол мажоритар тогтолцооны хувьд нэг мандаттай тойргийн бүлэгт чиглэн хэрэгждэг.

Квотын түвшин тухайн намын хэлбэр, хэмжээнээс хамаарна. Намын жагсаалт дараах нөхцөлд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд үр дүнтэй байдаг. Үүнд:

(1) *Олон нам, ялангуяа хэд хэдэн том нам намын квотын бодлогыг хэрэгжүүлж байх;*

(2) *Намын нэр дэвшигчдэд тавих эмэгтэйчүүдийн квот харьцангуй өндөр байх;*

(3) *Ойлгоход хялбар, хүлээн зөвшөөрөгдсөн соёлын уламжлалтай уялдсан байх;*

(4) *Нам зохион байгуулалтын тогтсон бүтэцтэй, нэр дэвшүүлэх албан ёсны үйл явцтай, намын дотоод байгууллага дүрмийн хэрэгжилтэд хяналтад тавьдаг байх. Намын нэр дэвшигчийг намын*

удирдлага үнэнч хэдэн дэмжигчээ шууд нэрийг нь дэвшүүлдэг буюу албан бус арга замаар тодруулдаг нөхцөлд эмэгтэйчүүдийн оролцоог баталгаажуулах боломж бага.

Эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх зорилгоор 1920-иод оноос намын дотор болон гадна улс төрийн үйл ажиллагаа явуулж ирсэн Баруун Европын намуудад квот үр дүнтэй хэрэгжиж ирсэн. Жагсаалтад нэг эмэгтэй л орж байсан үеэс эхлээд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоо тэнцэх үе хүртэл намуудын олгох квотын хэмжээ байнга өсч ирэв. 1990-ээд онд намуудын албан бус зорилт, санаачлага, зөвлөмж илүү албан ёсны бодлого болж батлагдах хандлага ажиглагдсан. Сонгуулийн пропорциональ тогтолцоог ашиглан эмэгтэйчүүдийн төлөөлөлд ахиц гарч байсан ч намын стратеги голлох үүрэг гүйцэтгэсэн. Өнөөдөр Шведэд ихэнх нам "сөөлжих" зарчим буюу эмэгтэйчүүд намын жагсаалтад зөвхөн 50 хувийг эзлээд зогсохгүй, эрэгтэйчүүдийн адил сонгогдох боломжоор хангагдах үүднээс жагсаалтад эрэгтэйчүүдтэй адил түвшинд, сөөлжлөн эрэмбэлэгдэх болжээ. Үүний дүнд тус улсын эмэгтэйчүүд парламентын нийт суудлын 45 хувийг эзэлж, энэ үзүүлэлтээр дэлхийд хоёрдугаарт жагсаж байна.

ШИГТГЭЭ 5. Шведийн улс төрийн намуудын сайн дурын квот

1921 онд санал өгөх эрхтэй болсныхоо дараа Шведийн эмэгтэйчүүд эмэгтэй нэр дэвшигчдийг сонгуулахаар улс төрийн намуудыг ятгах ажилд идэвхтэй оролцон 1930-1940-өөд оноос эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх, жагсаалтад байршуулах чиглэлээр нэлээд шургуу тэмцэл өрнүүлж ирсэн. Эмэгтэйчүүд Фредрика Бремерийн Холбоо зэрэг нам бус байгууллагуудын хүч чармайлтыг намуудын эмэгтэйчүүдийн бүлгэмтэй уялдуулан, холбох замаар улс төрийн намуудыг дотоод, гадаад аль аль талаас нь шахан дайчилж байв. Намын эмэгтэй гишүүд сонгуулийн нэрсийн жагсаалтад эмэгтэйчүүдийг сонгогдох боломжтой байршилд бичүүлэхээр намынхаа удирдлагыг лоббидож байсан бол иргэний нийгмийн бүлэглэлүүд эмэгтэйчүүдийн улс төрд эзлэх байр суурийн тухай ойлголтыг элит болон олон нийтийн дунд нэмэгдүүлэхийг эрмэлзэн ажиллаж байв.

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн үргэлжилсээр байсан боловч 1960-аад оны сүүлч, 1970-аад оны эхээр улс төрийн намын удирдлагууд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх тал дээр илүү хатуу амлалт өгч эхэлсэн. 1970, 1980-аад оны үед бараг бүхий л томоохон нам намын дотоод болон сонгуульд нэр дэвшүүлэх зорилго тавьсны дотор эмэгтэйчүүдийг ихэнхдээ аль ч хүйсэд хамаарах квотыг 40-өөс багагүй хувиар тогтоож байв. Энэ хүч чармайлтын үр дүнд 1988 оны сонгууль хүртэл Шведийн Рихстагт эмэгтэйчүүдийн эзлэх жин 38 хувь хүртэл өсчээ.

Гэвч 1991 онд парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх жин 1920 оноос хойш анх удаа буурч, 38-аас 34 хувь болжээ. Энэ нь бүх нам эмэгтэйчүүдийг элсүүлэх тал дээр дутагдалтай байсныг харуулсан. Хэдийгээр эмэгтэйчүүд өөрийн намын дотор лобби хийж эхэлсэн боловч маш олон эмэгтэй нам харгалзалгүй уулзаж, "урт оймсыг дэмжих"

нэртэй нам хоорондын сүлжээг байгуулж эхэлсэн. Үүний гол зорилго нь эмэгтэйчүүдийг намын нэрсийн жагсаалтад сонгогдох боломжтой байранд тавихын тулд намуудад шахалт үзүүлэхэд оршиж байв. Намууд тэдний тавьсан алхмуудыг хэрэгжүүлэхгүй тохиолдолд дараагийн сонгуульд эмэгтэйчүүдийн намыг бий болгон оролцохоор тохиролцсон байна.

Энэ зорилгоор эмэгтэйчүүд "varannan damernas" буюу "хоёрын нэг нь хатагтай нарын төлөө" гэсэн шинэлэг уриан дор нэгдэж эхэлсэн. "Varannan damernas" нь орон нутаг дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн талаарх илтгэлд анх дурдагдсан. Учир нь орон нутагт хоёр дахь дуу болгонд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бүжгэнд урьдаг аж. Энэ уламжлалыг зарим хүн "ардчилсан бүжиг" хэмээх нь ч бий. Зарим нам квотын хэмжээг үг дуугүй дэмжсэн бол бусад нь тэгш төлөөлөл хэрэгтэй, шаардлагатай гэсэн хатуу амлалт өгсөн. Олон нам эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийг нэрсийн жагсаалтад солбиж оруулдаг зарчмыг бататгахын хэрээр эмэгтэйчүүдийн төлөөлөл 50 хувь руу ойртсоор байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн төлөөлөл 1994 онд 41 хувь болж өссөн бол 1998 онд 43 хувь, 2002 онд 45 хувь, 2006 онд 47 хувь, 2010 онд 45 хувьд тус тус хүрчээ.

Хэдийгээр албан ёсны квотын бодлого нэвтрүүлээгүй нам байгаа боловч дийлэнх нь эмэгтэйчүүдийн нэр дэвшүүлэх идэвхтэй арга хэмжээ авахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөөд байна. Үүнийг Шведийн жишээнээс харж болно. Олонх уламжлалт чиг баримжаатай нам болон зарим улс үндэстний хувьд жендэрийн квотыг дангаар нь яривал маргаан дагуулдаг. Ийм нөхцөлд улс төрийн намууд эмэгтэйчүүдийн албан ёсны квотын оронд албан бус зорилт, шалгуур тавьдаг. Эдгээр арга хэмжээ нь квот гэсэн нэршилгүй тул энэ төрлийн "зөөлөн квот"-ын тоог гаргахад хэцүү. Гэхдээ эмэгтэйчүүдийн төлөөллийг бодитой нэмэгдүүлэхэд чиглэсэн байдаг тул ихэнхдээ албан ёсны намын квоттой ижил үүрэг гүйцэтгэдэг.

"Зөөлөн квот"-ын үндсэн хоёр хэлбэрт эмэгтэй нэр дэвшигчдийн тоо нэмэгдэхэд шууд нөлөөлөх албан бус зорилт, зөвлөмж болон сонгуульд өрсөлдөхөд нэг шат ойртуулан шууд бус нөлөө үзүүлэх намын дотоод бүтэц дэх квот багтана.[56] Хэдий эдгээрийг албан ёсны квотоос ялгаатай авч үзэхийг оролддог ч төрөл бүрийн улс төрийн байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөллийг баталгаатай биш боловч нэмэгдүүлэх зорилготой байдаг. Зарим тохиолдолд зөвхөн боломжит эмэгтэй нэр дэвшигчид анхаарал хандуулах зорилго агуулах нь бий. Иймд хэдий адил зорилгын тухай дурдсан боловч "зөөлөн квот"-ыг албан ёсны квотын зорилго, үзэл санаанаас ухарсан арга хэмжээ хэмээн тооцож болно.

Янз бүрийн квотын бодлогын нийтлэг зорилго нь эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх үйл явцыг шинэчлэх замаар эрэлт нийлүүлэлтийн аль алиныг идэвхжүүлэх явдал юм. Улс төрийн харилцаанд элсүүлэх үйл явцыг (1) улс төрийн албан тушаал хаших шаардлага хангасан олон тооны иргэд, (2) улс төрийн албан тушаал хаших хүсэл сонирхол бүхий хэсэг бүлэг иргэн, (3) улс төрийн албан тушаалд өрсөлдөхөөр нэр дэвшсэн цөөн

тооны иргэд, (4) улс төрийн албан тушаалд сонгогдсон цөөн иргэн гэсэн дараалал бүхий загвараар илэрхийлж болно.[57] Үүнд нөлөөлөх гадны хүчин зүйл байхгүй тохиолдолд эдгээр үе шат бүрт байгаа хувь хүний шинж байдал ижил гэж үзэж болно. Боловсролын түвшин, нам доторх байр суурь, хууль тогтоох туршлага, өөрийгөө илэрхийлэх чадвар, санхүүгийн чадавхи, улс төрийн хүрээлэл, төрөл садангийн холбоо, олонд танигдсан байдал, гишүүнчлэл, зохион байгуулах чадвар зэрэг үзүүлэлтээр нэр дэвшигчдийг ангилж болох боловч эмэгтэй, цөөнхийн төлөөлөл, залуусыг гадуур үлдэх хандлага илт ажиглагддаг.[58]

Үүний дагуу эмэгтэйчүүдийн төлөөлөл хүн амд эзлэх хувиасаа бага байдгийн шалтгааныг жендэрийн ялгаанаас үүдэн гарах улс төрийн амбиц, сонгон шалгаруулалт дахь улс төрийн элитийн өрөөсгөл хандлага, эсвэл эрэгтэйчүүдийг сонгохыг илүүд үздэг сонгогчдын өрөөсгөл үзэл бодол зэрэгтэй холбон тайлбарладаг. 3 дахь тайлбарыг сонгогчид эрэгтэй, эмэгтэйчүүдэд ижил түвшний санаа өгдөг төдийгүй эмэгтэйчүүдийг илүүд үзэх тал байдаг гэсэн баримтаар үгүйсгэдэг.[59] Эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх талаарх ихэнх судалгаанд эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн харилцан хамаарал, гүйцэтгэл үүрэг зэргийг анхаарсан байдаг. Ийм нөхцөлд квот нь намын удирлагыг уламжлалт арга барилаасаа хөндийрч, эмэгтэй нэр дэвшигчийг судлах чиглэлд түлхсэн эрэлтийн талыг барьсан шийдэл болж өгдөг. Нөгөө талаас, улс төрийн тавцан эмэгтэйчүүдэд нээлттэй гэсэн ойлголт төрүүлэх замаар эмэгтэйчүүдийн идэвхийг нэмэгдүүлж буй нийлүүлэлтийн талыг барьсан шийдвэр гэж ч үзэж болно.

VIII. ЧАДАВХИ БЭХЖҮҮЛЭХ

Иргэний нийгмийн байгууллагууд голлон сонгуульт албан тушаалд очих эмэгтэйчүүдийн хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх квотоос өөр аргуудыг боловсруулсан байдаг. Эдгээр нь нийлүүлэлтэд голлон чиглэдэг ч улс төрд эмэгтэйчүүдийн хэрэгцээ өндөр байгааг олон нийтэд мэдэгдэж, улмаар намын удирдлага, сонгогчдын дунд эмэгтэй нэр дэвшигчийн эрэлтийг нэмэгдүүлдэг. Чадавхи бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа нь квот нэвтрүүлэх боломж хомс улсуудад эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Квотыг ашигладаг улсуудын хувьд ч ач холбогдолтой. Учир нь энэ хоёр стратеги нь эрэлт, нийлүүлэлтийн асуудлыг шийдэхэд цогц байдлаар хандах боломж бүрдүүлдэг.

Иргэний нийгмээс гадна бусад талууд ч ийм санаачлагад хувь нэмрээ оруулдаг бөгөөд эдгээр санаачлагыг хэдий ялгаатай ч зарим талаар давхарддаг 3 бүлэгт хувааж болно. Үүнд: тэгш бололцооны санаачлага (нэр дэвшигчийг сургах, элсүүлэх арга хэмжээ, мэдлэгийн сүлжээ), хэвшмэл төсөөллөөс ангижруулж, зөв ойлголт өгөх санаачлага (иргэний боловсрол, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах), улс төрийн намын санаачлага (эмэгтэйчүүдийн бүлгэм, санхүүжилт босгох, эмэгтэйчүүдийн нам) багтана. Эдгээр арга хэмжээ нь эмэгтэйчүүд чадвар, мэргэшил дутагдсан гэсэн үг биш харин тэдний өмнө улс төрийн амьдралд хөл тавих боломж эрэгтэйчүүдтэй харьцуулахад хаалттай байсантай холбоотой.[60] Эмэгтэйчүүдийн оролцоог хангахад эмэгтэй нэр дэвшигчдийг хөхүүлэн дэмжиж, жендэрийн тэгш бус байдлын талаарх хэвшмэл төсөөлөлтэй тэмцэж, эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих намын тогтолцоог онцолсон цогц хандлага шаардлагатайг дээрх гурван төрлийн санаачлага харуулж байна.

Тэгш бололцоог хангах санаачлага

Олон эмэгтэй улс төрийн албан тушаал хаших чадвартай байдаг боловч эрэгтэйчүүдтэй харьцуулахад жендэрийн алагчлалын улмаас улс төрийн албанд мэргэшин ажиллахад шаардагдах мэдээллийг авах боломж нь сул байдаг. Ийм учраас эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийг нэмэгдүүлэхэд энэ талын мэдлэгийг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр нэн чухал.

Дагуулан сургах

Улс төрийн нам эсвэл нам бус иргэний нийгмийн бүлэг зохион байгуулсан ирээдүйн болон одоогийн эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан сургалтын хөтөлбөр бол чадавхи бэхжүүлэх чиглэлээр шууд авах арга хэмжээний нэг юм. Саяхны нэгэн жишээ бол Папуа Шинэ Гвинейд болсон кампанит ажил байв. Уг ажлын хүрээнд улс төрийн идэвх, оролцоогоо дээшлүүлэхийг хүссэн эмэгтэй нэр дэвшигчдэд зориулан олон нийтийн өмнө ярих болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй харилцах чадварын сургалт зохион байгуулжээ (Шигтгээ 6-г харна уу). Түүнчлэн хамгийн анхны радио нэвтрүүлэг “эмэгтэйчүүдийг парламентад бэлтгэх нь” сэдвээр 2012 оны 4 дүгээр сард болж, тус улсын эмэгтэй нэр дэвшигчдийг хууль тогтоох асуудлаар болон парламентын хэлэлцүүлэгт оролцох туршлага олгосон байна. Үүнтэй адил Кирибати, Маршаллын арлууд, Палауд эмэгтэйчүүдэд зориулсан загвар парламентын хуралдаан зохион байгуулсан нь эмэгтэйчүүдийн чадавхийг нэмэгдүүлээд зогсохгүй сонгогчдыг мэдээллээр хангасан арга хэмжээ болжээ.

ШИГТГЭЭ 6. **Папуа Шинэ Гвиней дэх эмэгтэй нэр дэвшигчдийн чадавхийг дээшлүүлэх**

Папуа Шинэ Гвиней нь мажоритар, альтернатив (хоёр болон түүнээс дээш боломжоос сонголт хийх) системээр сонгогддог 109 гишүүний бүрэлдэхүүнтэй нэг танхимт парламенттай улс юм. 89 гишүүн нээлттэй тойргоос сонгогддог бол үлдсэн 20 гишүүн орон нутгийн тойргоос сонгогддог. Папуа Шинэ Гвиней нь Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах зэрэг олон улсын конвенц, гэрээнүүдэд нэгдэн орсон боловч сонгуульт албан дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байсаар ирсэн түүхтэй. 1975 онд Австралиас тусгаар тогтнолоо олж авснаас хойш зөвхөн 3 эмэгтэй Папуа Шинэ Гвинейн Парламентад сонгогдоод байна. 2007 оны 6 дугаар сард болсон сонгуульд 102 эмэгтэй нэр дэвшиж оролцсон боловч зөвхөн нэг нь л парламентын 109 гишүүний нэг болсон. Дээрх тоо нь эмэгтэйчүүдийн төлөөлөл Номхон далайн арлуудад нийтдээ сул хэмээн өмнө дурдсан дүгнэлтийн нэг жишээ болж байна.

Суудал хадгалах аргын талаарх мэтгэлцээн:

Нөхцөл байдал ийм байгаа нь шинэчлэлийн тухай томоохон хэлэлцүүлэг эрчимтэй өрнөхөд хүргэж, ялангуяа эмэгтэйчүүдийн бүлэг, идэвхтнүүд суудал хадгалах арга хэмжээ бий болгохыг эрмэлзэн кампанит ажиллагаа явуулах болсон. Парламент дахь цорын ганц эмэгтэй гишүүн бөгөөд Нийгмийн хөгжлийн сайд Даме Карол Кидү 2008 онд урьд өмнө нь хэрэглэгдэж байгаагүй Үндсэн хуулийн заалтыг ашиглан гурван эмэгтэйг парламентад томилон суулгах саналыг Үндэсний гүйцэтгэх зөвлөл (Засгийн

Газар)-д өргөн барьсан. Үндэсний гүйцэтгэх зөвлөл дээрх саналыг хүлээн авсан боловч Парламентын хэлэлцүүлгийн үеэр уг санал дэмжигдээгүй ажээ.

Эмэгтэйчүүд муж болгонд 1 суудал (2011 онд 2 шинэ муж бий болсон), нийслэлийн нэг дүүрэгт (тойрогт) 1 суудал, нийт 22 суудлыг эмэгтэйчүүдэд зориулан хадгалахаар кампанит ажиллагаа өрнүүлсэн байна. Парламент 2011 оны 11 дүгээр сард Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, 22 нэмэлт суудал (16,7 хувь) эмэгтэйчүүдэд хуваарилах асуудлаар санал хураасан. Гэвч санал хурааалтыг хэрэгжүүлэхээс өмнө сонгуулийн тойргийн шинэ хил заагийг тогтоох зорилгоор Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болсон бөгөөд түүнд шаардагдах 73 саналыг авч чадаагүй. Хэдий тийм ч Эмэгтэйчүүдийн Үндэсний Зөвлөл 2012 онд батлагдсан Тэгш байдал ба тэгш оролцооны хуулийн хүрээнд 2012 оны 6 дугаар сард сонгуульд шинэ суудлууд бий болгох чиглэлээр Засгийн газрыг уриалан идэвхтэй ажиллаж байна.

Нэр дэвшигчдэд зориулсан сургалт

Хэдийгээр институцын шинэчлэл явагдаагүй боловч 2012 оны 6 дугаар сарын сонгуульд оролцох эмэгтэй нэр дэвшигчдийн ур чадвар, мэдлэгийг сайжруулах зорилгоор чадварыг дээшлүүлэх хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрийг Нийгмийн хөгжлийн яамны (газрын) ивээл дор Эмэгтэйчүүдийн хөгжлийн алба эхлүүлсэн байна. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Эмэгтэйчүүд удирдах албанд” төсөл, мөн АНУ-ын Ардчилсан институцын (байгууллагуудын) төв зэрэг байгууллага уг стратегийг (бодлогыг) дэмжих зорилгоор техникийн тусламж үзүүлсэн. Түүнчлэн Папуа Шинэ Гвинейн Сонгуулийн хороо, бүртгэлтэй намууд, мөн иргэний нийгмийн байгууллагууд хамтран гар биеэ оролцсон байна. Кампанит үйл ажиллагаа эхлэхээс 15 сарын өмнө төлөвлөлт эхэлсэн. Ардчилсан институцын (байгууллагуудын) төв нь нэр дэвшигчид болон сонгуулийн ажлын менежерүүдийг хамарсан 100 гаруй эмэгтэйд зориулсан сургалт зохион байгуулахад голлох үүрэгтэй оролцоод байна.

Эмэгтэйчүүд парламентын туршлага олж авахад зориулсан үйл ажиллагааны нээлт

2011 онд Номхон далайн бүс нутагт анх удаа эмэгтэйчүүдэд зориулсан дуураймал парламентыг амжилттай зохион байгуулсан. Энэхүү дуураймал парламентын үйл ажиллагааг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Номхон далайн бүсийн төв, Номхон далайн Форумын байнгын алба зэрэг байгууллага Кирибати, Маршаллын арлууд болон Папауд зохион байгуулсан. 2012 оны 4 дүгээр сард ODW, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, НҮБ-ын Эмэгтэйчүүд зэрэг байгууллагаас 60 гаруй эмэгтэйг сонгон 7 хоногийн хугацаатай эмэгтэйчүүдэд зориулсан “Парламентын практик” арга хэмжээнд оролцуулсан. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр нь Засгийн газрууд, Сонгуулийн хороод, олон нийтийн мэдээллийн

хэрэгслүүд, НҮБ-ын байгууллагуудын оролцоотойгоор уг хурлыгр Торт Моресбид зохион явуулсан. Сургалтын гол зорилго нь эмэгтэйчүүдийг парламентын болон хууль тогтоох журамтай танилцуулах, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, илтгэх чадварыг сайжруулах, Папуа Шинэ Гвиней-тэй холбоотой бодлогын асуудлаар мэтгэлцэхэд бэлтгэх явдал байв. Парламентын дуураймал хурлуудыг радиогоор олон нийтэд шууд цацсан. Эмэгтэйчүүд дуураймал Засгийн газар, дуураймал сөрөг хүчинд хуваагдсан ба “Асуултын цаг”-аар үйл ажиллагаа эхэлсэн. Эмэгтэй нэр дэвшигчид хөдөө тосгоны эрүүл мэндийн үйлчилгээ, “бүх нийтийн боловсрол”-ын бодлого, хээл хахуулийн асуудал, хариуцлагатай хүрээлэн буй орчны бодлого зэрэг сэдвээр асуулт асууж, хариулт өгч байлаа. Асуултын цагийн дараа санал болгосон хуульд дүгнэлт хийх, мөн нэмэлт өөрчлөлтүүдийг хэлэлцэх зэрэгт эмэгтэйчүүдийн чадварыг тэлэх зорилгоор нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийн тухай дуураймал хуулийн төслийн хэлэлцүүлэг зохиов. Сургалтын дараа олон нийтийн шууд цацалтыг хүлээн авч сонссон улс төрийн намууд эмэгтэй нэр дэвшигчдийг намын жагсаалтад оруулж эхэлсэн байна.

Дагуулан сургах хөтөлбөрийн хүрээнд сонгуульт албан тушаал хашиж байгаа эмэгтэй удирдагчийг шинэ залуу нэр дэвшигчидтэй уулзуулж, урт хугацаат харилцаа тогтооход нь дэмжлэг үзүүлдэг.

Норвегийн Хөдөлмөрийн намын эмэгтэйчүүд “Эмэгтэйчүүд чадна” гэсэн хөтөлбөр гарган, дэлхийн 25 гаруй улс орны эмэгтэйчүүдийг сургалтад хамруулав. Норвегийн Ардын тусламжийн сангийн санхүүжилтээр явагдсан сургалт ардчилал ба эмэгтэйчүүдийн оролцоо, харилцахуйн ухаан, мэтгэлцэх чадвар, мэдээллийн хэрэгсэлтэй харилцах чадвар, яриа хэлэлцээ, сүлжээ, өмгөөлөл,

эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх сэдвүүдийг хамарсан.[61]

Конгресст шинээр сонгогдсон гишүүдэд зориулж Харвардын их сургуулийн Улс төр судлалын хүрээлэнд хоёр намын хамтарсан сургалтын хөтөлбөр 1972 оноос эхлэн явагдаж байна. Хөтөлбөрийн хүрээнд гадаад бодлого, эрүүл мэнд, холбооны нэгдсэн төсөв зэрэг чухал сэдвээр эрчимжүүлсэн семинар зохион байгуулж, улс төрийн үзэл бодлын өөр өөр өнцгөөс тайлбар өгөх нэр хүндтэй судлаач, албан тушаалтан нарыг урьж оролцуулж байна. Конгрессийн ордонд шинээр хүрэлцэн ирсэн гишүүнийг эхний хугацаанд шаардагдах дадлагажих сургалт мөн зохион байгуулдаг. Энэхүү сургалт Конгресс, Цагаан ордон, яамд, зохицуулах агентлагууд, үндэсний хэвлэл мэдээллийн одоогийн болон хуучин гишүүдийн удирдлага дор явагдаж Вашингтонд ажил хэрхэн явагддаг талаар төвлөрч заадаг байна. Түүнчлэн шинэ гишүүдийн хувьд Конгрессд орохын өмнө нам харгалзалгүйгээр бусад гишүүдтэй танилцах албан бус боломж өгдөг байна. Хөтөлбөр Конгрессийн ордонд итгэлцэл, хамтын ажиллагааны уур амьсгал бүрдүүлэхэд дэмжлэг болдог. Шинээр сонгогдсон хотын дарга, мужийн захирагч нарт зориулсан ийм сургалт мөн явагддаг.

Элсүүлэх

Тэгш боломж бүрдүүлэх дараагийн зүйл бол хэтдээ болон ойрын хугацаанд сонгуульд өрсөлдөх эмэгтэй нэр дэвшигчийг тодруулж, зоригжуулан дэмжих, элсүүлэх санаачлага юм. Үүнийг ихэвчлэн иргэний нийгмийн байгууллагууд зохион байгуулдаг бөгөөд ялангуяа АНУ-д сайтар хөгжсөн байдаг. АНУ сонгуулийн мажоритар тогтолцоотой, жендэрийн квотод таагүй ханддагийн улмаас эмэгтэйчүүдийн улс төр дэх төлөөллийг огцом нэмэх боломжгүй байдаг. Иймээс ч учраас энэ төрлийн төслүүд эмэгтэйчүүдийн ойлголт, сэтгэхүйд өөрчлөлт оруулах урт хугацааны зорилго агуулдаг.

Ратжерс их сургуулийн Америкийн эмэгтэйчүүд ба улс төр судлалын төвийн санаачлан хэрэгжүүлж буй “2012” төсөл үндэсний хэмжээнд сүүлийн үед танигдаж эхлээд байна.[62] Энэхүү кампанит ажил нь 45 болон түүнээс дээш настай, улс төрийн тавцанд хангалтгүй төлөөлөл бүхий санхүү, цаг уур, шинжлэх ухаан, технологи, жижиг бизнесийн зэрэг салбарын эмэгтэйчүүдэд зориулагдсан. Энэ насны эмэгтэйчүүд ажил мэргэжлийн хувьд өндөр амжилтад хүрсэн, гэр бүлийн хариуцлага нь багассан (хүүхдүүд нь том болсон), санхүүгийн хувьд хараат бус болсон байдаг учраас “2012” төсөл тэднийг сонгон ажиллаж байна. Эдгээр эмэгтэйчүүдтэй холбоо тогтоохын тулд салбарын хурлууд дээр хууль тогтоогчоор ажиллаж байсан эмэгтэйчүүдээр лекц уншуулж, сонирхлоо илэрхийлсэн тохиолдолд судалгааны төв, кампанит ажилд бэлтгэх хөтөлбөр, санхүүжилт босгох сүлжээний талаар мэдээлэл өгч амжилтад хүрэхэд нь дэмжлэг үзүүлдэг.

Харин “Сонгуулийн эхлэл” хэмээх бүлэг хүн амын залуу хэсгийг анхаарч ажилладаг. Үүнийгээ АНУ-д эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлье гэвэл аль болох залуугаас нь улс төрд хөл тавиулж, сонгуульд оролцуулах ёстой гэж үздэг.[63] Тус бүлэг нь Залуу эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллын хөтөлбөрөөрөө ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн охидод эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллын ач холбогдлыг ухуулан таниулж, тэднийг

олны өмнө өөрийгөө илэрхийлэх, бусадтай холбогдож ажиллах, камерын өмнө өөрийгөө авч явах зэрэгт сургадаг. “Сонгуулийн эхлэл” болон Вол мартын хамтарсан тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд оюутан насны 7 бүсгүйг сонгон шалгаруулж, эмэгтэй парламентын гишүүдийн албанд нэг семестрийн хугацаанд дадлага хийлгэн Баасан гарагуудад улс төрийн албаны тухай дэлгэрэнгүй сургалтад хамруулдаг байна.

АНУ-д хэрэгжиж буй дараачийн хоёр санаачлагын нэг бол “Тэр сонгуульд өрсөлдөх ёстой” нэртэй нэр дэвшүүлэх, мэдээллээр хангах цахим төв юм. Тус төв нь эмэгтэйчүүдийг сонгуульд өрсөлдөхийг бодож үзэхийг санал болгодог бөгөөд эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд нэр дэвших талаар бага боддог гэсэн статистик мэдээнд үндэслэн үйл ажиллагаа явуулдаг аж. Нэгэнт нэр дэвшихээр шийдсэн тохиолдолд адил хувиар л ялдаг ажээ. Хэзээ нэгэн цагт сонгуульд өрсөлдөх ёстой гэж итгэж байгаа эмэгтэй хүнийхээ мэдээллийг иргэд тус хөтөлбөрт хүргүүлснээр тухайн эмэгтэйг зоригжуулж, дараагийн алхам болгож юу хийх талаар мэдээлэл, зөвлөмж өгдөг аж.[64] Үүнтэй төстэй нэгэн төсөл бол “Түүнийг томилъё” юм. Энэ төслийг “Эмэгтэйчүүдийн кампанит ажлын сан” зохион байгуулдаг. Томилгоот албан тушаал эрхлэхийг хүсэж буй эмэгтэйчүүдэд зориулан үндэсний мэдээллийн сан байгуулсан бөгөөд тэнд тохирох албан тушаалыг гармагц мэдэгдэж, одоо алба хашиж байгаа эмэгтэйчүүдийн чадвар, мэргэшлийн тухай мэдээлэл өгч, ажил мэргэжлийн зөвлөгөө өгдөг.[65]

Мэдлэгийн сүлжээ

Тэгш боломж бүрдүүлэх стратегийн 3 дахь зүйл нь мэдлэгийн сүлжээ байгуулах замаар мэдээлэл хуваалцаж, олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх үр дүнтэй арга хэлбэрийн тухай хилийн дээс харгалзалгүйгээр санал солилцож, боломжит эмэгтэй нэр дэвшигчийг тодруулж, сонгуульд өрсөлдөж буй эмэгтэйчүүдийн кампанит ажилд дэмжлэг туслалцаа үзүүлдэг. Дэлхийн хэмжээнд хэсэг үндэстэн дамнасан ТББ нэгдэж, Улс төр дэх эмэгтэйчүүдийн олон улсын мэдлэгийн сан буюу iKNOWPolitics (http://www.iknowpolitics.org/)-г байгуулсан. Тус вэбсайтыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан, Олон улсын харилцааны үндэсний ардчилсан хүрээлэн, Олон улсын парламентын холбоо, Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэнгээс санхүүжүүлдэг тус төслийг улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх эрмэлзлэлтэй парламентын гишүүн, нэр дэвшигч, улс төрийн намууд, судлаач, оюутан, мэргэжилтнүүдэд үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий “Цахим ажлын орчин” гэж үзэж болно (Шигтгээ 7-г харна уу).

ШИГТГЭЭ 7. Чадамжи бэхжүүлэх: “Би улс төр мэднэ” цахим хуудас

Улс төрч эмэгтэйчүүдийн Олон улсын мэдлэгийн сүлжээ нь дэлхийн улс төрч эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийн талаар харилцан мэдээлэл солилцох цахим хурал зөвлөгөөн гэж хэлж болно. Үүний гол зорилго нь технологи буюу цахим хуудсаар дамжуулан улс төрийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн оролцоо, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино. Цахим хуудас нь номын санд нэвтрэх, бусад хэрэглэгч, судлаач, хуульчийн шинжилгээтэй танилцах, өөрийн мэдээллийг байршуулах, мэдээлэл солилцох, гишүүний тавьсан асуултад нэгдсэн баталгаатай хариу өгөх, сайн туршлагаа хуваалцах боломж олгодог. Аль болох олон хэрэглэгчдэд хүртээлтэй болгох үүднээс цахим хуудсын агуулга, нөөцийг Араб, Англи, Франц, Испани хэл дээр хөрвүүлэн тавьсан.

Энэ төсөл нь ул төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх эрмэлзэлтэй хэд хэдэн байгууллагын хамтын санаачлага юм. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр нь үндэсний болон дэлхий дахинд тулгарч буй сорилтуудыг иргэн төвтэй арга барилаар шийдэхэд нь Засгийн газруудад дэмжлэг үзүүлдэг ба өнөөдөр дэлхийн 166 оронд үйл ажиллагаагаа явуулж байна. Тус хөтөлбөрөөс намуудын эмэгтэй болон бие даагч гишүүдийг улс төрд ороход нь дэмжлэг үзүүлэх, тэдний чадавхи бэхжүүлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан нь эмэгтэйчүүдэд мэдэл олгох, жендэрийн тэгш эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрүүд, стратегиудад санхүүгийн болон мэргэжлийн туслалцаа үзүүлдэг. Эмэгтэй удирдагчдыг бэлтгэх, сонгуульд саналаа өгөх ба нэр дэвшихэд шаардагдах мэдлэг чадвараар хангах замаар Засгийн газрын бүх шатан дахь эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нь сангийн нэг томоохон зорилт юм. Үндэсний ардчиллын хүрээлэн нь ардчиллын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх, ардчиллын институцуудыг бий болгоход хувь нэмэр оруулж буй нийгэм, улс төрийн удирдагчдад бодит туслалцаа үзүүлдэг. Мөн тус хүрээлэн сонгуульт албан тушаалд ажиллах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх, намын болон нийгмийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн удирдах чадварыг дээшлүүлэх зорилгоор “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн нь ардчилсан бүтцийг бий болгох, ардчилсан үйл явцыг өрнүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг Засгийн газар хоорондын байгууллага юм. Тус хүрээлэн нь нийгмийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх чиглэлээр харьцуулсан дүн шинжилгээ хийж, судалгаа явуулдаг. Олон улсын парламентын холбоо нь дэлхийн улс орнуудын парламентуудын байгууллага юм. Энэ байгууллага нь улс төр дэх эмэгтэйчүүдийн асуудлаарх ойлголтыг нэмэгдүүлэх, ерөнхий чиг хандлагыг тодорхойлох зорилготой, олон судалгаа хийдэг. Мөн эмэгтэй гишүүд, нэр дэвшигчдэд зориулсан төрөл бүрийн төслүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгдөг.

Европын хувьд Брюссельд төвтэй “Европын эмэгтэйчүүдийн лобби” Европын парламентад эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллага 1990 оноос хойш Европын парламентын сонгууль бүрийн өмнө намуудын эмэгтэй нэр дэвшигчдийн тоог нэмэгдүүлэх зорилготой кампанит ажил зохион байгуулж байв. Чингэхдээ Европын 2500 орчим эмэгтэйчүүдийн бүлгээс бүрдсэн сүлжээг ашиглаж байсны зэрэгцээ нэр дэвшүүлэх явцдаа жендэрийн тэнцвэртэй байдалд анхаарлаа хандуулах талаар энгийн иргэд тус тусын улсын эрх баригчдад шахалт үзүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн лобби хийх арга хэрэгслийг цахим хуудсаараа дамжуулан олон хэлээр бэлтгэн тарааж, олон нийтийн хүртээл болгож байв.[66]

Хэвшмэл төсөөлөлтэй тэмцэж, зөв ойлголт, мэдлэгийг гүнзгийрүүлэх

Сонгогдох хүртэлх үйл явцын янз бүрийн шатанд байгаа эмэгтэйчүүдийн тоо, түүний дотор нэр дэвшсэн, сонгогдсон эмэгтэйчүүдийн тоог ажиглах нь тэгш боломж бүрдүүлэх стандарт арга зам юм. Энэ талаар явцын хяналт тавьж, тайлагнах үүргийг үндэсний статистикийн газар эсвэл парламентын нэгж хариуцна.

Эмэгтэйчүүд улс төрийн албан тушаалд ажиллах нь зохимжгүй гэсэн үзэл бодол эрэгтэйчүүдийг улс төртэй, эмэгтэйчүүдийг гэр бүлтэй хамаатуулан ойлгодог жендэрийн хэвшмэл төсөөллөөс үүдэн үүсч бэхждэг. Энэхүү хэвшмэл бодлыг арилгаснаар улс төр хөөх эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэхээс гадна сонгогч болон намуудын эмэгтэй нэр дэвшигчийн талаарх үзэл бодол өөрчлөгддөг. Үүний тулд иргэдийн улс төрийн тухай ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн төрөл бүрийн хэвлэл мэдээллийн кампанит ажил явуулна. Улс төрийн тавцанд жендэрийн тэнцвэр алдагдаад байгаа өнөөгийн байдал болон ардчиллыг бэхжүүлэхийн тулд эмэгтэйчүүдийг сонгох хэрэгцээний талаар иргэд, эрх баригчдын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх замаар эмэгтэй нэр дэвшигчдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэсэн хэд хэдэн кампанит ажил Ази, Номхон далайн бүс нутагт явагдаж байсан билээ.

Хэдэн жилийн өмнөх нэг жишээ бол Португалийн тэнцвэртэй парламент юм. Европын парламентын 3 эмэгтэй гишүүний санаачлагаар 1994 оны парламентын сонгуулийн өмнөх 115 эрэгтэй, 115 эмэгтэй улс төрчийн оролцоотой нэг өдрийн парламентын хуралдаан болж ардчилал, Португал дахь эмэгтэйчүүдийн үүрэг, иргэншил ба тэнцвэртэй байдал зэрэг сэдвээр хэлэлцсэн. Европын комиссын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан тус арга хэмжээ эрэгтэй, эмэгтэйчүүдийн төлөөлөл парламентад тэнцүү байхад жендэрийн тэнцвэр ямар байхыг үзүүлэхээр зорьжээ.[67]

Үүнээс илүү өргөн хүрээг хамарсан мэдээллийн кампанит ажил 1997 онд Исландад хийгдсэн. Олон намын хамтарсан парламентын хороо зохих санхүүжилт бүхий 5 жилийн (1997-2002) кампанит ажил өрнүүлж, хошин зар сурталчилгаа, сургалт семинар, боловсрол, мэдээллийн сүлжээ, нийтийн уулзалт, дагуулан сургах зэрэг арга хэмжээгээр дамжуулан улс төрд эмэгтэйчүүдийн эзлэх жинг нэмэгдүүлэхийг зорьсон байна. Сурталчилгааны материалууд нь жендэрийн тэгш байдлын асуудлыг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд нь нөлөөлдөг гэдэг талаас нь харуулж, Засгийн

газрын өндөр түвшин дэх жендэрийн хэвшмэл ойлголтыг шүүмжилсэн агуулгатай байв.

Мэдээллийн кампанит ажлын саяхны жишээ гэвэл Чехийн парламентын 2006 оны сонгуулийн өмнө Фирум 50-ийн санхүүжилтээр Прага хотын метро, гудамж талбайд зурагт сурталчилгаа байрлуулсан ажлыг дурдаж болно. Зурагт самбарт “Чамд үнэхээр сонголт байна уу” гэсэн бичвэр, урт өмд, зангианы зураг байв. Үүгээр эрэгтэйчүүдийн дунд зарим ялгаа байдаг ч сонголтын хувьд эмэгтэйчүүдийг оруулаагүй бол боломж үнэхээр хумигдаж байна гэсэн санаа агуулсан. Туркт эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих холбооноос бүтээлч, шат дараалсан мэдээллийн кампанит ажлыг зохион байгуулсан. 2009 сонгуулийн өмнө тэд Туркийн улс төрийн гол гурван эрэгтэй удирдагчийг мөр мөрөө нийлүүлсэн байдлаар илэрхийлж, энэхүү гурван намыг эрэгтэй нэр дэвшигч нарыг илүүд үзэж байгаагаараа нэгдмэл гэсэн утгатай бичиг оруулсан байна.

Улс төрийн намын санаачлага

Иргэний нийгмийн зүгээс зохион байгуулж буй кампанит ажлын зэрэгцээ улс төрийн намууд дотооддоо эмэгтэй нэр дэвшигчдийн хувь хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүчин чармайлт гаргаж байна. Улс төрийн нам дахь эмэгтэйчүүдийн дуу хоолойг эмэгтэйчүүдийн бүлэг, эсвэл тухайн намын гэж үзэж болох бүх эмэгтэй гишүүнийг нэгтгэсэн албан ёсны байгууллага дэмжиж ирсэн уламжлалтай. Барууны орнуудад эмэгтэйчүүд санал өгөх эрхтэй болсноор эмэгтэйчүүдийн саналыг татах үүднээс эмэгтэйчүүдийн бүлгүүд байгуулагдаж байв. Ийм бүлгүүд Коммунист орнуудад эмэгтэй ажилчдыг нэгтгэх, нам бус эмэгтэйчүүдээс дэмжлэг авахад ихээхэн ач холбогдолтой байв. Гэвч дээрх хоёр жишээний хувь эмэгтэйчүүдийн бүлгийн гол зорилго нь эмэгтэйчүүдийн эрх ашгийн төлөө нам үйлчлэхээс илүүтэйгээр эмэгтэйчүүд намын эрх ашгийн төлөө үйлчлэх явдал байв. Гэвч он цаг өнгөрөхийн хэрээр олон орны эмэгтэйчүүдийн бүлэг эмэгтэй нэр дэвшигчдийн тоог нэмэгдүүлэх талаар намын даргын амлалтыг авч, эмэгтэйчүүдийн асуудлыг чухалчлах замаар улс төрийн нам доторх эмэгтэйчүүдэд зориулсан чухал талбар болж иржээ.[68] Ногоон нам зэрэг шинэхэн нам эмэгтэйчүүдийн бүлэг байгуулснаар эмэгтэйчүүдийн асуудлыг саланги асуудал мэт үзэх эрсдэлтэй гэж үздэг тул нам дотроо эмэгтэйчүүдийн бүлэг байгуулдаггүй. Олон жилийн түүхтэй намуудын хувьд нам доторх эмэгтэйчүүдийн бүлгийг үгүй хийх оролдлогууд төдийлөн амжилтад хүрдэггүй нь тэд эмэгтэйчүүдтэй холбогдолтой чухал асуудлыг улс төрийн асуудал болгон анхаарлын төвд оруулахад чухал үүрэг гүйцэтгэж чадаж байгаатай холбоотой.[69]

Санхүүжилт олох

Намд суурилсан стратегийн хоёр дахь багц нь эмэгтэй нэр дэвшигчдэд урам зориг өгөх, мөн кампанит ажил амжилттай явуулахад шаардлагатай нөөц, хөрөнгөтэй байх үүднээс санхүүжилт олох санаачлага гаргах явдал юм. Намын кампанит ажилд зориулан төсвөөс мөнгө хуваарилж өгдөггүй Монгол зэрэг улсад санхүүжилт олох нь эмэгтэйчүүдийн хувьд томоохон бэрхшээл тулгардаг. Санхүүжилт босгох байгууллагууд дунд хамгийн алдартай нь АНУ-д төвтэй ЭМИЛИ-гийн жагсаалт юм. 1985 онд байгуулагдсан энэ байгууллага эмэгтэйчүүдийг элсүүлж, бэлтгэхээс гадна тэдний нэрийн өмнөөс дэлхий даяарх ивээн тэтгэгчдээс кампанит

ажилд зарцуулах мөнгөн дэмжлэг цуглуулахад нь оролцдог.[70] ЭМИЛИ-гийн жагсаалтын загварт түшиглэн Австрали, Их Британи, Итали зэрэг улсуудад дээрхтэй адил төстэй санхүүжилт босгон бүлгүүд байгуулагдаад байна.

Квоттой эсвэл улс төрийн намууд нь төсвөөс санхүүждэг орнуудад үүнээс өөр бусад механизм ч ашигладаг. Намууд эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигч нарын 50, 50 хувийн квотыг зөрчихийн хэрээр мөнгөн торгууль нь нэмэгддэг талаар өмнө дурдсан Францын жишээнээс харж болно. Энэ арга хэмжээ төсвөөс санхүүждэг жижиг нам болон олон эрэгтэй нэр дэвшигчийг дэвшүүлэх санхүүгийн чадавхитай том намд харилцан адилгүй нөлөө үзүүлдэг.[71] Дээрх аргын дутагдлыг ойлгосон зарим улсад эмэгтэй нэр дэвшигчдийн тоог нэмэгдүүлэх үүднээс “урамшууллын” арга хэрэглэж байна. Жишээ нь сүүлийн жилүүдэд Хорватад тухайн намын эмэгтэй нэр дэвшигч парламентад сонгогдсон тохиолдолд тус намд олгох санхүүжилтийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлж байгаа аж. Үүнтэй адилаар эмэгтэйчүүдийг сонгогдоход дэмжлэг үзүүлэх үүднээс Мароккогийн Засгийн газар 2009 оны орон нутгийн сонгуульд эмэгтэй нэр дэвшигч хамгийн олонтой намд санхүүгийн дэмжлэг өгөх санал дэвшүүлжээ. Хараахан түгэн дэлгэрээгүй ч эдгээр туршлага зарим талаар улс төрийн намын санхүүжилтийг тунгалаг болгоход эерэгээр нөлөөлж болох юм.

Эмэгтэйчүүдийн нам

Зөв ойлголт, мэдлэг түгээж, эмэгтэйчүүд сонгогдоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн, дараагийн стратеги нь түгээмэл бус, намд тулгуурласан бөгөөд эмэгтэйчүүдийн нам байгуулах явдал юм. 1995 онд Литвийн эмэгтэйчүүдийн 13 байгууллага улс төрийн бие даасан тоглогч болоход квот шаардлагагүй гэдгийг олон нийтэд харуулах зорилгоор Литвийн эмэгтэйчүүдийн намыг үүсгэн байгуулсан. Намын даргаар тус улсын Ерөнхий сайд асан Казимиера Прунскиени ажиллав. Тус нам 1996 оны сонгуульд 24 намаас 7 дугаар байрт жагсаж, намуудыг цочроож байв.[72] Энэ төрлийн санаачлагууд одоо байгаа улс төрийн намаас “дээш” гарч, эмэгтэйчүүдийн дуу хоолойг сонсгох гэсэн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнөөс урган гардаг бөгөөд энэ нь Исланд, Хойд Ирландын жишээнд тод илэрдэг.[73]

IX. СОНГУУЛИАР БҮРДДЭГ БАЙГУУЛЛАГЫН ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ДҮРЭМ, ЖУРАМ

